



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**



**БҮХ НИЙТИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ҮҮРГИЙН САН**

# ТАНЫ ЦАХИМ БОЛОВСРОЛД **ГАРЫН АВЛАГА**

Улаанбаатар хот  
2017 он

# ТАНЫ ЦАХИМ БОЛОВСРОЛД ГАРЫН АВЛАГА

Монгол улсыг иргэдийн харилцаа холбоо, мэдээлийн технологийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн захиалгаар бүтээв.

Эмхэтгэсэн: Б.Золзаяа  
П.Пүрэвсүрэн  
Ч.Болор-Эрдэнэ  
М.Номин

Хянасан: Х.Азжаргал

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Э.Энхтуяа  
Хэвлэсэн: “Алмаз Пресс” ХХК

*Энэхүү гарын авлагыг олон нийтэд үнэгүй тарааж, интернэтэд нээлттэйгээр байршуулна. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх болон бусад хэлбэрээр ашиглах бол эх сурвалжийг заавал дурдана. Худалдахыг хориглоно.*

## ӨМНӨХ ҮГ

Бүх Нийтийн Үйлчилгээний Үүргийн Сан (БНҮҮС) нь Харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн түгээмэл үйлчилгээг хүн амын байршил, амьжиргаа түвшинг үл хамааран хүргэх боломж бүрдүүлж, сүлжээгээ өргөтгөх, шинээр байгуулахыг эрхэм зорилгоо болгоно.

БНҮҮС-гийн санхүүжилтээр Монгол Улсын хэмжээнд 2017 оны байдлаар 300 гаруй сум, суурин газарт харилцаа холбооны үйлчилгээг хүртээмжтэй байлгах зорилгоор суурин болон хөдөлгөөнт холбооны чанартай үйлчилгээг нэвтрүүлэх, хамрах хүрээг сайжруулж, дэд бүтэц байгуулах, интернетийн үнийг бууруулж, хурдыг нь нэмэгдүүлэн ажиллаж байна. Түүнчлэн хөдөө орон нутгийн иргэд, малчдад харилцаа холбоо, мэдээллийн технологийн анхан шатны боловсрол олгох, хэрэглээг нь нэмэгдүүлэх зорилгоор жил бүр гарын авлага бэлтгэдэг билээ. Мөн радио, телевизийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулж, шуудангийн үйлчилгээг орон нутгийн алслагдсан хэрэглэгчдэд шуурхай хүргэх, давтамжийг нэмэгдүүлэх бодлого барин, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэн, амжилттай ажиллаж байна.

Дэд бүтцийн хөгжил тодорхой түвшинд хүрч, иргэд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэх нөхцөл бололцоо нээлттэй болсон. Ингэснээр хүн бүр харилцаа холбооны технологийг ашиглан "дэлхийн хүн" болох боломж бүрдэж буй. Өөрөөр хэлбэл, иргэн бүр дэлхийн аль ч улс орны нийгэм, эдийн засгийн үйл явдал, хөгжил дэвшил, шинжлэх ухааны ололт амжилтын талаарх хүссэн мэдээллээ олж авах, ашиглах боломжтой болсон.

Иргэдийн цахим боловсрол, харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх мэдлэг, хэрэглээний ур чадварыг сайжруулах, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилго бүхий цахим боловсрол олгох гарын авлага танд хүрч байна.

*Нолмын цагаан буян дэлгэрэх болтугай*

## I. МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ

### 1.1 ЦАХИМ ЕРТӨНЦӨД ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ

Интернэт орчин, олон нийтийн сүлжээ, ухаалаг утас та бидний амьдралын өдөр тутмын хэрэглээ болсон. Тэгвэл аливаа хэрэглэгч цахим харилцааны талаар мэдлэгтэй болсноор нэр төрөө хамгаалах, хүсээгүй харилцаа, үл таних нэгний халдлагаас өөрийгөө хамгаалах чадвартай болох юм.

#### Олон нийтийн сүлжээнд зураг, бичлэг тавихдаа анхаарах зүйл



Зураг, бичлэг, үг өгүүлбэр болон сэтгэл хөдлөлөө найзуудтайгаа хуваалцах боломжийг олон нийтийн сүлжээ бидэнд олгодог. Биеэр уулзах боломжгүй эсвэл хэзээ ч танилцахгүй байсан хүмүүстэй холбогдож, тэдний санаа бодлыг сонсох, танилцаж, нөхөрлөх, аливааг олон талаас нь хардаг, мэдээллийн эх сурвалжтай болох зэрэг олон давуу талыг бид цахим ертөнцөөс олж авдаг. Түүнчлэн олон

нийтийн сүлжээнд зураг, бичлэг тавих нь найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ дурсамжтай мөчөө хуваалцах сайхан арга боловч хүүхдийнхээ болон хувийн зургуудаа олонд дэлгэхэд эрсдэл үүсдгийг мартаж болохгүй. Эдгээр эрсдэлээс сэргийлэхийн тулд танд дараах зөвлөгөөг хүргэе.

#### Олон нийтийн газар болон хувийн орон зай

Хэрэв та олон нийтийн газар байгаа (жишээ нь музей) бол зураг авахыг зөвшөөрдөг, эсэх, та зурганд орсон хүмүүсийн зургийг бусадтай хуваалцаж болох, эсэхийг мэдэх хэрэгтэй. Мөн хурим, хүүхдийн үсний найр зэрэг олон хүн цугласан арга хэмжээ зохиож байгаа бол зургаа олон нийтийн сүлжээнд тавихыг зөвшөөрөх, эсэхээ урьдчилан мэдэгдээрэй.

### 1.2 НИЙТЛЭХЭЭСЭЭ ӨМНӨ БОД

Интернэтэд нэгэнт тавигдсан зураг, бичлэгийг цааш түгээх, хувилах, өөрчлөн ашиглах боломж бусдад бий болдог. Иймд хянаж чадахгүй болохоосоо өмнө сайтар эргэцүүл.

- Хэн хэн энэ зургийг үзэх боломжтой вэ?
- Энэ зурганд өөр хүмүүс бий юу. Тэд зургаа интернэтэд байршуулахыг хүсэх үү?
- Энэ зураг хэн нэгнийг доромжилсон өнгө аястай эсвэл олон нийтийн доог тохуу болох уу гэдгийг дэнслээрэй.

Түүнчлэн хүүхдүүдийн талаарх мэдээлэлтэй зураг бол бүр ч илүү бодох хэрэгтэй. Ийм төрлийн зураг нь цахим орчинд эрсдэл дагуулдаг болох нь батлагдсан юм.

### Тохиргоо

Зураг, бичлэгээ нийтлэхдээ тухайн төхөөрөмж болон олон нийтийн сүлжээний тохиргоогоо шалгаарай. Хэн таны зургийг үзэж болох, эсэхийг та тохируулж болно.

### Зураг, бичлэг хуваалцах өөр арга замууд

Дараах аргуудыг хэрэглэснээр та бусадтай зураг, бичлэг хуваалцахдаа илүү хяналттай байж чадна. Үүнд:

- И-мэйлээр зургаа хуваалцах
- Нууц үг, хаяг ашиглаж байж зураг үзэх боломжтой болдог, аюулгүй портал ашиглах
- Утасны мессежээр зураг явуулах.

### Байршил

Зургаа нийтэлснээр та өөрийн байршлыг бусдад мэдээлж байх магадлалтай. Хэрэв ингэхийг хүсэхгүй байвал ашиглаж буй төхөөрөмж дээрх GPS-ийг унтраах, ямар аппликейшн таны байршлын мэдээллийг авдгийг шалгаж, унтраах гэх мэт сонголт бий.

## 1.3 НИЙГМИЙН СҮЛЖЭЭ БА ОНЛАЙН НАЙЗУУД

### Бодит амьдрал дээр ч тэд миний найз мөн үү?

Нийгмийн сүлжээ, интернэт мессеж, чат ашиглах нь найзуудтайгаа холбоотой байх, шинэ найзтай болох хамгийн түгээмэл хэлбэр. Гэвч тэр хүмүүсийг та бодит амьдрал дээр мэддэггүй бол энэ нь тун эрсдэлтэй. Та огт танихгүй, найдваргүй хүмүүстэй ч хувийн мэдээллээ хуваалцаж байж болзошгүй гэдгийг сана. Ганц л мессеж, зураг, бичлэг нэгэнт тараасан бол та түүнийг хянах боломжгүй.

Нийгмийн сүлжээний аюулгүй байдлын тухай үндсэн ойлголт

- Танихгүй хүмүүстэй найз битгий бол
- Нууц үгээ бусадтай бүү хуваалц
- Хувийн мэдээллээ бүү хуваалц
- Нэр хүндээ хамгаал. Хуваалцах гэж буй зүйлээ бусдад харуулахыг үнэхээр хүсэж байна уу гэдгээ сайтар бод
- Хэнд итгэхээ сайн бод. Дүр эсгэгч ч байж мэднэ
- Танихгүй хүмүүстэй харилцахдаа вэб камер битгий ашигла



- Аливаа зүйлийг нийтлэх, түгээх, татаж авах болон чатлахын өмнө сайтар бод
- Онлайн найзтайгаа уулзахдаа анхааралтай бай. Чи яг хэнтэй уулзаж байгаагаа мэдэх үү гэдгээ бод
- Хэрвээ цахимаар танилцсан найзтайгаа уулзах гэж байгаа бол насанд хүрсэн хүн эсвэл итгэлтэй найзтайгаа хамт яв. Өдрийн цагаар, олон хүнтэй газар уулз.

#### 1.4 ОНЛАЙН ТОГЛООМ

Хэт ихээр тоглох нь чиний сурлага, гэр бүлийн амьдралд сөрөг нөлөөтэй.

Онлайнаар болон компьютерын тоглоом тоглох нь мэдээж хөгжилтэй. Гэхдээ чи хэр их тоглож байна, хэнтэй тоглож байна гэдгээ үргэлж цэнэж, болгоомжтой хандах хэрэгтэй. Тиймээс хэрвээ тоглож байхдаа хэн нэгэнтэй чатлах зэргээр харилцаж байгаа бол өөрийнхөө хувийн мэдээллийг нууцлаж, хамгаалж байх хэрэгтэй.



#### Анхаарах зүйлс

- Хэр их тоглож байгаагаа анзаарч байх
- Найз нөхөдтэйгөө уулзах, дуртай спортоороо хичээллэх зэрэг бусад зүйлдээ цаг гаргахаа битгий мартаарай

#### Өөрийгөө хамгаалах

- Хэрвээ хэн нэгэн тоглогч чамд таагүй санагдвал түүнийг жагсаалтаас хасаж, блоклох хэрэгтэй
- Хувийн мэдээллээ нууцал
- Тоглож байх үедээ бусдыгаа хүндэл

#### 1.5 ОНЛАЙН ХУДАЛДАА

##### Би мөнгө төлснийхөө хариуд юу авах вэ?

Онлайн худалдааны болон дуудлага худалдааны сайтууд нь мөнгө, цаг хэмнэх, хүссэн үедээ худалдаа хийх боломж бидэнд олгодог. Гэхдээ онлайн худалдаа болон энгийн худалдааны ялгааг мэдэх хэрэгтэй.



#### Анхаарах зүйлс

- Нэр хүндтэй, үйл ажиллагааны найдвартай компанитай харилц
- Үнэ болон хүргэлтийн нөхцөл, шаардлагыг нь мэдэж, судал
- Үйлчилгээний гэрээний нөхцөлийг нь сайтар уншиж судал
- Худалдаа хийгчтэй холбогдон хэзээ, хэрхэн бараа бүтээгдэхүүнээ авахаа урьдчилан лавлах хэрэгтэй

### Өөрийгөө хамгаалах

- Сайтын дүрэм, нөхцөлийг унш
- Захиалгыг цуцлах, тавьсан шаардлагыг хүлээж авах боломжтой, эсэхийг нь сайтар нягтал
- Хэрвээ хүүхэд бол эцэг эх юм уу, насанд хүрсэн хүмүүсээс тусламж ав
- Мөнгөн гүйлгээ хийх үедээ нууцлал, хамгааллыг нь нягтал
- Хүргэлтийн үйлчилгээг зогсоох, татгалзах нөхцөлийг нь мэдэж байх хэрэгтэй

## II. ЦАХИМ ЕРТӨНЦӨД ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Цахим ертөнц үүссэн цагаасаа хойш шинжлэх ухаан, технологийн дэвшилттэй хавсран өргөжин, хөгжиж бидний ажил, амьдралын орон зайд томоохон байр суурь эзэлж буй. Цаашид ч өргөжсөөр байх тул цахим орчны зохистой хэрэглээг дадал болгох нь эцэг эхчүүд бидний хүүхдийнхээ ирээдүйн сайн сайханд нь оруулж буй нэгэн чухал хувь нэмэр юм.



Олон Улсын ЦахилгаанХолбооны Байгууллага(ОУЦХБ)-аас хүүхдийг насны ангиллаар гурав хувааж интернэтийг ашиглах тодорхой чиглэл, зөвлөмжийг боловсруулан гаргасан байна. Үүнд:

### 5-7 насны хүүхдүүд:

Технологитой харилцаж сурах үе. Энэ үед нь түүнийг эцэг эхийнх нь аль нэг, насанд хүрсэн хүн тогтмол хянаж байх шаардлагатай. Шүүлтүүрийн програмыг хэрэглэх, аюулгүй сайтуудын жагсаалтыг гаргах нь зүйтэй. Энэ бүлгийнхэн нийлмэл мэдээллийг ойлгож, хүлээн авч чадахгүй байх магадлалтай. Иймээс тэдэнд интернэт дэх аюулгүй байдлын үндэс, ёс зүйн ерөнхий ойлголтыг бий болгоход гол зорилго оршино. Энэ бүлгийн хүүхдүүдийн эцэг эх тэдэнд зориулж гаргасан зөвлөмж чиглэлийг мөрдөн ажиллах нь зүйтэй. Тэд бол тусламж хэрэгтэй, хамгийн залуу хэрэглэгчдийн бүлэг.

**8-12 насны хүүхдүүд:** Энэ үеийнхэн шилжилтийн насныхан байдаг. Интернэтийн талаар анхны ойлголт туршлагатай болсон үе. Залуу хүн болж төлөвших насныхан тул тэдэнд ойлгож, сонирхсон маш олон асуудал байдаг. Түүндээ хариулт авах сонирхолдоо хөтлөгдөн одоо байгаа хязгаараасаа давж болзошгүй. Шүүлтүүрийн програм болон өөр бусад техник хэрэгслийг хэрэглэх нь ашигтай. Энэ насныхан аливаа контент болон холбоо харилцаанд

шүүмжлэлтэй ханддаггүй нь элдэв сөрөг зүйлсэд татагдах магадлалтай болгодог.

**13 ба түүнээс дээш насныхан:**Энэ насны бүлгийнхэн технологийг мэргэшсэн хэмжээнд хүртэл сайн эзэмшиж, хэн нэгний хараа хяналтгүйгээр ашигладаг залуу үеийнхэн юм. Шүүлтүүрийн програм ач холбогдол багатай ч нэмэлт үүргээ гүйцэтгэсээр байх болно. Өөрийн хувийн амьдралыг бусдын хараа хяналт, оролцоогүй байлгах, олон найзтай болох гэсэн асар их хүсэл эрмэлзэлтэй. Мөн насны онцлогоосоо шалтгаалан сексийн асуудлыг сонирхдог, байгалиас заяасан хэрэгт дурламтгай зандаа хөтлөгдөн өөрсдийгөө аюултай байдалд оруулж болзошгүй байдаг. Энэ тохиолдолд тэдэнд өөрийгөө яаж аюулгүй байлгах вэ гэдгийг ойлгуулах шаардлагатай.

## 2.1 ХҮҮХДИЙНХЭЭ ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГ ХЯНАХ ХЭРЭГТЭЙ

Яагаад эцэг, эхчүүд хүүхдийнхээ интернэт хэрэглээг хянах шаардлагатай вэ?



**Шалтгаан 1:** Цахим орчинд бага насны хүүхэд санамсаргүй байдлаар зохисгүй, ёс бус, насанд хүрэгчдэд зориулагдсан мэдээ мэдээлэл, цахим хуудасруу нэвтрэн орж түүний талаарх мэдээллийг авснаар хүүхдийн зан араншин өөрчлөгдөх, хүмүүжлийн доголдол үүсэхэрсдэлтэй. Тэр бүү хэл, тэдний ертөнцийг харах үзэл суртал нь хүртэл өөрчлөгдөх аюултай.

**Шалтгаан 2:** Интернэт сүлжээнд олон төрлийн гэмт хэрэг гардаг ба хүүхэд санамсаргүй байдлаар өөрийн хувийн мэдээллийг тараах,

олон нийтийн цахим сүлжээгээр үл таних хүмүүстэй холбоо тогтоох зэргээс үүдэн цахим гэмт хэргийн золиос болох сөрөг талтай.


**Шалтгаан 3:** Интернэт хэрэглэгчдэд их, бага тодорхой хэмжээний бэрхшээл учруулдаг олон төрлийн вирус цахим ертөнцөд оршин байдаг. Түүнийг санамсаргүйгээр өөрийн компьютерт татаж авснаар хакерууд таны компьютерт байгаа бүхий л файл, хувийн бусад мэдээллийг хуулбарлан авах боломжтой төдийгүй компьютерыг тань эвдлэх, гацаах, дахин ашиглах аргагүй болгох аюултай

## 2.2 ХҮҮХДИЙНХЭЭ ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГ ХЯНАХ ҮЙЛДЛИЙН СИСТЕМИЙН ТОХИРГООГ ХЭРХЭН ВЭ?

Эцэг эхчүүд хүүхдийнхээ цахим хэрэглээг хянахын тулд ParentalControls цэсийг идэвхжүүлэх тохиргоо хийх хэрэгтэй. Үүнд:



Start button -г дарж **Control Panel** цэс рүү орно.




Дараа нь **User Accounts and Family Safety** цэсний **Set up parental controls for any user**-рүү орно.

**Parental Controls** тохиргоо хийхдээ хүүхдийн ашигладаг **account** -ийг нь сонгоно.




Та дээрх тохиргоо (**Parental Control**)-г өөрчлөх боломжгүй байхаар нууц үг сонгох хэрэгтэй.





Хэрэв та харагдахгүй байгаа нууц үгийг компьютер хэрэглэж байгаа хүнд харуулахыг хүсвэл **Type a password hint** хэсэгт бичнэ.



Та хүүхдийн цахим орчинд юу хийж байгааг хянахдаа **Parental Controls** → **User Controls** цэсний **On, enforce current setting**-г идэвхжүүлээд **Windows Settings** –н **Allow and block specific programs**-руу орж хүүхдийнхээ интернэт ашигласан цаг, тоглоом, програм гэх мэт олон төрлийн тохиргоо хийж, хяналт тавих боломжтой.





Хүүхдийн компьютер хэрэглэх хугацаанд хязгаарлалт хийхдээ: **Parental Controls** → **User Controls** хуудасны **Time limits** –рүү орж тохиргоо хийнэ.






**Компьютер тоглоомын хяналт:**

**Parental Controls**→**User Controls** цэсний **Games**—г сонгон хүүхдийн тоглодог тоглоомыг үнэлгээ, агуулга эсвэл компьютер дээрх тоглоомын нэрээр нь хязгаарлалт хийж болно.



Програмын хяналт: Parental Controls→User Controls цэсний Which programs can child use? гэсэн асуултын дор байрлах Child can only use the programs I allow дээр дарж хүүхдэдээ ашиглуулахгүй байхыг хүссэн програмыг сонгож Ок товчлуурыг дарна.




Windows7 нь Vista үйлдлийн системтэй адил Web filter байхгүй учир Windows Live Family Safety програмыг нэмэлтээр суурилуулна. Энэ нь цахим хуудасруу нэвтрүүлэхгүй мөн хүүхдийн нэвтрэн орсон цахим хуудасны талаарх мэдээллийг авах боломжтой.

### 2.3 YOUTUBE RESTRICTED MODE БУЮУ ЗОХИСГҮЙ БИЧЛЭГИЙГ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙХ ТОХИРГООГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?



**Бүх төрлийн вэб хөтөч дээр:**

1. YouTube хаягаараа нэвтрэн орно
2. Доош гүйлгэж хуудасны доор байрлах **Restricted Mode** товч дээр дарна
3. **Он**буюу асаах, **off** буюу унтраах сонголтыг хийнэ.




Нэг удаа **Restricted Mode** –ийг асаасан байхад тухайн хөтөч дээр хүүхэд үзэхэд тохиромжгүй контентууд хязгаарлагдах болно. Мөн зөвхөн таны хаягаар нэвтэрч **Restricted Mode** - ийг цуцлах боломжтой.


**Android:**

Та юуны түрүүнд бүх вэб хөтөч дээрээ дараах тохиргоог хийх хэрэгтэй. **Multiple profile** дэмждэг хөтөч дээр **profile** болгонд идэвхжүүлнэ.


1. Өөрийн хаягаар нэвтрэн орно




2. **Settings** цэсрүү орно




3. **Settings > General**-г сонгоно






4. **SafeSearch filtering** дарж **strict**-г сонгоно




### iPhone болон iPad

1. Өөрийн хаягаар нэвтрэн орно



3. **Settings** дээр дарна



4. Гарч ирэх цэснээс **strict** сонгоно

### III. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХУВЬ ХҮНИЙ НУУЦЛАЛ, ХАМГААЛЛЫН ТУХАЙ

#### 3.1 НАЙДВАРТАЙ НУУЦ ҮГ ХЭРХЭН ҮҮСГЭХ ВЭ?

Найдвартай нууц үг яагаадүүсгэх шаардлагатай гэж та гайхаж байж болох юм. Ихэнх вэб сайт аюулгүй байдалдаа онцгойлон анхаардаг. Гэсэн хэдий ч хэн нэгэнд таны хувийн мэдээллийг хулгайлах боломж байсаар ирсэн. Үүнийг ерөнхийд нь хакердах гэж нэрлэдэг. Иймд хакеруудаас данс, хувийн мэдээллээ хамгаалах гол арга зам нь найдвартай нууц үг юм. Найдвартай нууц үг танд санахад амархан байх ёстой ч бусад хүний хувьд хэцүү байх шаардлагатай. Ингээд найдвартай нууц үг үүсгэх аргаас танилцуулъя.

- Нэр, төрсөн өдөр, хэрэглэгчийн нэр, мэйл хаяг гэх мэт хувийн мэдээллээ хэзээ ч битгий ашиглаарай. Учир нь эдгээр хувийн мэдээлэл ихэвчлэн олон нийтэд нээлттэй, түүнийг мэдэх боломжтой байдаг тул хэн нэгэн таны нууц үгийг мэдэхэд хялбар болж байгаа юм.
- Таны нууц үг урт байх шаардлагатай. Тодруулбал, зургаагаас багагүй тэмдэгттэй байх нь зүйтэй.
- Хаяг бүртээ адилхан нууц үг битгий ашигла. Хэрэв хэн нэгэн таны нэг хаягийн нууц үгийг олж авбал таны бүх хаяг эрсдэлд орно.
- Таны нууц үг тоо, тэмдэгт, том, жижиг үсгээс бүрдэх ёстой.
- Утга агуулаагүй, дурын, замбараагүй үг ашиглах нь зүйтэй.

Дээрх аргуудаас гадна найдвартай нууц үг үүсгэх хэрэгслүүдийг ашиглах боломжтой юм. Ийм хэрэгслүүдээс найдвартай нууц үгийн жишээг та харж болно. Тухайлбал, <https://strongpasswordgenerator.com/> цахим хуудаснаас та найдвартай нууц үгийн хэлбэр, үндсэн нөхцөлийг мэдэх боломжтой. Ийм хэрэгслүүдийг хайлтын системээс “StrongPasswordGenerator” гэж бичээд олж болно.

Түгээмэл ашигладаг зохимжгүй нууц үгсийн жишээ бол хүүхдийнхээ нэр, нас, төрсөн огноог бичих юм. Мөн гэрийн хаягийн мэдээллээр нууц үг үүсгэх нь зохимжгүй. Хэрэглэгчдийн гаргадаг өөр нэг алдаа бол нэвтрэх нэрээ яг тэр чигээр нь нууц үг болгон ашиглах явдал юм.

#### Цахим орчин дахь хувийн мэдээллээ хэрхэн устгах вэ?

Цахим орчин дахь хувийн мэдээлэл гэдэгт ихэвчлэн төрсөн он, сар, өдөр, хаяг, гар утас болон суурин утасны дугаар, цахим шууданг ойлгоно. Гэхдээ энэ нь хувийн мэдээллийн бүрэн жагсаалт биш. Учир нь цахим орчин дахь хувийн мэдээллийг задалж үзвэл тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичгийг хэлнэ.

Гэвч цахим орчинд хувь хүний олон төрлийн хувийн мэдээлэл задарсан байдаг. Үүнд бид өөрсдөө буруутай төдийгүй бусад хүний оролцоо ч нөлөөлдөг. Иймд цахим орчин дахь хувийн мэдээллээ хэрхэн устгах талаар дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

Онлайн худалдан авалт, олон нийтийн сүлжээ, цахим хуудасны хэрэглэгчийн бүртгэлээ устгах буюу идэвхгүй болгох

Та өөрийн хувийн мэдээллийг олон нийт үзэх боломжтойгоор интернэтэд байршуулсан юм биш биз? Хэрэв тийм бол өөрийн хаягийг устгах буюу хаах, идэвхгүй болгох боломж бий. Үүнийг хүсэхгүй бол, хаягтаа нууцлалын тохиргоо хийх нь зүйтэй. Хэрэв нууцлалын тохиргоо нь хангалтгүй бол өөрийн хувийн мэдээллийг өөрчлөх буюу бодит бус мэдээллээр сольж болох юм. Дашрамд дуулгахад, таны хувийн мэдээллийг цахим орчноос устгаж өгөх төлбөрт үйлчилгээ байдаг. Ийм үйлчилгээ авах, эсэх нь таны сонголт.

### **Мэдээлэл цуглуулдаг цахим хуудсаас өөрийн мэдээллээ устгах**

Хэрэглэгчийн хувийн мэдээлэл болон зан үйлийн хэвшлийг цуглуулдаг маш олон төрлийн (Гүүгл, Фэйсбүүк гэх мэт)компани бий. Тэдгээр компанийн хувьд таны цахим орчин дахь бүх төрлийн үйлдэл, мэдээллийг бүртгэн өгөгдөл болгож, түүнийгээ сонирхсон этгээдэд зарж борлуулдаг. Иймд таны ямар мэдээлэл аль компанид байгааг өөрийн нэрээр хайж мэдэх нь чухал юм. Таны хувьд ийм компаниудтай хэлэлцээ хийж мэдээллээ устгуулах юм уу эсвэл хувийн мэдээллийг цахим орчноос устгаж өгөх төлбөрт үйлчилгээ авах боломж бий. Гэхдээ энд анхаарах зүйл нь ямар хугацааны мэдээллийг устгах, таны мэдээллийн санг дахин үүсгэх, эсэх юм.

### **Хувийн мэдээллээ цахим хуудаснаас шууд устгах**

Таны хувийн мэдээлэл хэзээ, хаана, ямар байдлаар байршиж байгааг хайлтын систем ашиглан мэдэх боломжтой. Ингээд та тухай мэдээллүүд хаана байгааг мэдсэн бол тухайн цахим хуудас, блогийн вэбмастер, админтай хувийн шугамаар холбоо тогтоож, мэдээллээ устгуулах нь зүйтэй. Тухайн цахим хуудасны эзний мэдээллийг олохын тулд **www.whois.com** зэрэг домэйн нэрийн мэдээллийн санг ашиглаж болно. Үүнээс гадна тухайн вэбсайтын “Бидний тухай”, “Миний тухай”, “Contact us” зэрэг хэсгээс холбоо барих хаягийг олж болно.

### **Таны мэдээллийг илрүүлсэн хайлтын үр дүнг устгуулах**

Bing, Yahoo, Google зэрэг хайлтын хүчирхэг системүүд бий. Үүнээс Гүүглийн хувьд хайлтын үр дүнг устгуулах хүсэлтийг шийдвэрлэх хэрэгсэлтэй. Тухайн цахим хуудасны админ таны хувийн мэдээллийг устгаагүй тохиолдолд энэ хэрэгслийг хэрэглэхэд тохиромжтой. Гүүглийн хэрэгсэл нь таны хувийн, чухал мэдээлэл болох банкны дансны дугаар, гарын үсэг, түүний зураг, таны зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн дүрс бичлэгийг устгах боломжтой юм.

### **И-мэйл хаягаа устгах**

И-мэйл хаягаа устгах арга нь таны хэрэглэж буй и-мэйлийн төрлөөс хамаарч харилцан адилгүй байдаг. Нэн түрүүнд өөрийн и-мэйл хаягаар нэвтэрч, дараа нь хаягаа устгах буюу хаах тохиргоог олно.

Эцэст нь хэлэхэд, дээрх алхмыг нэг өдөрт л багтаан дуусгачих боломжгүй бөгөөд интернэтээс бүрэн устгаж болохгүй зүйлс байдгийг санах нь зүйтэй. Гол анхаарах зүйл бол, интернэтийг цаашид ашигласаар байх бол та ямар мэдээллийг, ямар хүрээнд цахим орчинд байршуулах, дамжуулахаа үргэлж бодож байх нь зүйтэй юм.



### **3.2 ЦАХИМ ОРЧИНД БАРИМТ, НОТОЛГООГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ БУСАДАД ТҮГЭЭХ НЬ ЯМАР ҮР ДАГАВАРТАЙ ВЭ?**

Баримт, нотолгоогүй буюу сураг төдий мэдээллийг цахим орчноор дамжуулан бусдад түгээснээр эхний өдөр хоёр хүнд, түүний маргааш ахиад хоёр хүнд хүрэх байдлаар 14 хоногт найман мянгаас багагүй хүнд хүрэх магадлалтай гэж үздэг.Зарим судлаачийн тооцоолсноор хэдэн өдөр, хэр олон хүнд нэг зэрэг хүргэснээс хамааран баримт, нотолгоогүй мэдээлэл тэр хэмжээгээр хүмүүсийн анхааралд ордог байна[2]. Энэ нь таны нягталж шалгаагүй, худал мэдээлэл буюу “хов жив”, “цуу яриа”-г олон хүнд хүргэж болохыг харуулж байгаа юм.

Тодорхой тохиолдол авч үзье. Зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон хувийн фэйсбүүкийн хуудсаар дамжуулан хүмүүс иргэн Г.А нь хүний амь насыг хөнөөсөн хэмээн нийтэлжээ. Үүнээс болж олон нийтийн зүгээс Г.А-г алуурчин гэж жигшин, зэвүүцэж байсан юм. Харин шүүхээс Г.А-г хүний амь нас хөнөөгөөгүй, хохирогчийн бие махбодод гэмтэл санаатай учруулсан хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ял шийтгэсэн байна.Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэснийг зөрчиж байгаа юм.Үүнээс гадна Иргэний хуулийн 21.5-д “...Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй” гэж заасан.Энэ нь бусад хүний дүрсийг олон нийтэд тараах эрхтэй гэж бодсон буюу өөрийгөө тийм эрхтэй хэмээн итгэсэн хүмүүсийн үйлдэлд хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болж байгаа юм.

Нөгөө талаар баримт, нотолгоогүй, сураг төдий мэдээллийг өөрөө бэлтгэж, түгээгээгүй ч тийм мэдээллийг дэмжиж цааш түгээх нь хууль зүйн хариуцлага хамтран хүлээх үндэслэл болдог. Мөн хэр олон хүнд хүргэснээс хамааран хариуцах гэм хорын хэмжээг тодорхойлохоор хуульд заасан байдаг. Мэдээлэлд дурдагдсан хувь хүн тодорхой хэмжээгээр буруутай буюу тийнхүү баримт, нотолгоогүй мэдээлэл бусдад түгэх болсон гол хүчин зүйл нь. Гэсэн хэдий ч уг мэдээллийг нь цацсан хүмүүсийг зөвтгөх шалтгаан болохгүй. Харин хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл тийнхүү худал мэдээллийг бусдад түгээхэд нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан мэдээлэл түгээсэн этгээдийн хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно.

Иймд “Ямар мэдээлэлд итгэх вэ?” буюу мэдээлэл хайх, ашиглах, нэгтгэн дүгнэх, үнэлэх, бүтээх, харилцах чадвараа хөгжүүлэх нь зүйтэй юм. Энэ чадварыг бий болгох, хөгжүүлэх олон арга зам бий.

## IV. ХЭРЭГТЭЙ МЭДЭЭЛЛЭЭ ИНТЕРНЭТЭЭС ХАЙЖ ОЛОХ ХЯЛБАР АРГА

Мэдээллийн эрин зуунд амьдарч буй бид өөрийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн амьдралын талаарх мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авдаг болсон. Гэвч яг хүссэн мэдээллээ, хүссэн цагтаа олж авах арга хэрэгслүүдийг төдийлөн сайн мэддэггүй. Тэгвэл цахим ертөнц буюу интернэтээс хүссэн мэдээллээ хайх зарим аргаас орууллаа.

### Хайлтын систем гэж юу вэ?

Интернэтээс мэдээлэл хайх үйл явцыг хөнгөвчлөх зориулалттай тусгай програм хангамжуудыг хайлтын систем гэнэ.


Улс орнууд өөр өөрийн гэсэн хайлтын системүүдтэй ч олон улсад хамгийн түгээмэл ашиглагддаг нь Google, Yahoo, MSN, Naver, Bing, Baidu, Yandex, Rambler, WolframAlpha зэрэг юм. Үүнээс англи хэл дээр өргөн хэрэглэгддэг системүүд нь Google, Yahoo, Bing.

### Google хайлтын системийн тухай

Бидний өргөн хэрэглэдэг Google хайлтын систем нь найман тэрбум вэб хуудас, 35 орны хэл дээрээс өөрийн хүссэн мэдээ, мэдээллийг хайх боломж олгодог аварга том хайлтын систем юм.

### Google-ээс хүссэн мэдээллээ хэрхэн хайх вэ?

Мэдээж хэрэг хамгийн анхны алхам бол webbrowser-ийнхоо хаяг дээр **www.google.com** гэж бичээд хайлтын систем рүүгээ орно. Тэгээд хайх зүйлээ бичиж **ENTER** дарна.




Зураг 1.

Мөн та зөвхөн түлхүүр үгээр хайх биш нарийвчилсан байдлаар оновчтой хайлт хийж өөрт хэрэгтэй мэдээллээ түргэн олж авах боломж бий. Жишээ нь, сүүлийн 24 цагт шинэчлэгдсэн цахим хуудаснаас эсвэл зөвхөн хар, цагаан зураг хайх гэх мэт тодорхой зүйлээ тэмдэглээд хайлтхийх боломжтой.

### Google-ээс хэрхэн нарийвчилсан хайлт хийх вэ?

1. “**Advanced Search/Нарийвчилсан хайлт**” цонхыг нээнэ. Тус цонхыг нээхийн тулд webbrowser дээрээ [https://www.google.com/advanced\\_search](https://www.google.com/advanced_search) гэж бичнэ.



all these words:

this exact word or phrase:

any of these words:


none of these words:

numbers ranging from:  
 to

Then narrow your results by...

Зураг 2.

- **all these words**-энд дурдсан бүх үгийг хайх
- **this exact word or phrase**-үг, өгүүлбэрээр хайх
- **any of these words**-үгсийн аль нэгээр хайх
- **none of these words**-энэ үгсийг хайхгүй
- **numbers ranging from**-энэ хоорондох тоог хайх



language:  
any language ▾

region:  
any region ▾

last update:  
anytime ▾

site or domain:

terms appearing:  
anywhere in the page ▾

SafeSearch:  
Show most relevant results ▾


file type:  
any format ▾

usage rights:  
not filtered by license ▾

Зураг 3.

- **language**-хэл сонгох
- **region**-газар зүйн байршил
- **last update**-сүүлд шинэчилсэн
- **site or domain**-цахим хуудасны хаяг эсвэл домэйн нэр
- **terms appearing**-нэр томъёоор хайх
- **safe search**-хамгаалалттай хайлт хийх
- **file type**-файлын төрөл сонгох
- **usage rights**-Хэрэглээний эрхтэй байх, эсэхийг сонгох

2. Нарийвчилсан зурган хайлт хийх бол **web browser дээрээ**[https://www.google.com/advanced\\_image\\_search](https://www.google.com/advanced_image_search) гэж бичиж орно.



Advanced Image Search

Find images with...

all these words:

this exact word or phrase:

any of these words:

none of these words:

Then narrow your results by...

Зураг 4.




image size:  
any size

aspect ratio:  
any aspect ratio

colors in image:  
 any color  full color  black & white  transparent

type of image:  
any type

region:  
any region

site or domain:

SafeSearch:  
Show most relevant results

file type:  
any format

usage rights:  
not filtered by license

Advanced Search

Зураг 5.

- **image size**-зурагны хэмжээ
- **aspect ratio**-хэмжээний төрлийг сонгох
- **colors in image**-зурагны өнгө сонгох
- **type of images**-зурагны хэмжээ сонгох

- **region**-газар зүйн байршил
- **site or domain**-цахим хуудасны хаяг эсвэл домэйн нэр
- **safe search**-хамгаалалттай хайлт хийх
- **file type**-файлын төрөл сонгох
- **usage right**-хэрэглээний эрхтэй байх, эсэхийг сонгох

## V. НИЙГМИЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭ

### 5.1 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХУУРАМЧ ХАЯГ, ТӨӨРӨГДҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙГ ЯЛГАН ТАНИХ НЬ

Твиттерийн нийт хаягийн ойролцоогоор 4% нь хуурамч байдаг. Энэ нь дунджаар 20 сая хуурамч хаяг твиттерт байгааг харуулж байна. Эдгээр хуурамч хаягийг ямар санаа, зорилготой болохыг тодорхойлоход амаргүй. Хэдийгээр твиттерийн дүрмээр “элэглэл”, “мэдээ мэдээлэл”, “тайлбар” болон «фэн хаяг» үүсгэхийг зөвшөөрдөг ч тийм хаяг нь албан ёсны биш буюу дээрх ангиллын хаяг гэдгийг тодотгосон байх шаардлага тавьдаг.

Монгол Улсад ч хуурамч хаягийн давалгаа бий. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн @altankhuuag\_mn хаягийг дуурайлгасан хаягаар мэдээллийг зориудаар гуйвуулж олон нийтийг нэг хэсэг төөрөгдүүлсэн. Энд “L” үсгийн оронд “i” үсгийг томоор бичиж “I” болгосон байгаа юм. Үүнтэй ойролцоо жишээ бол Монголын медиа корпорацийн Ийгл Ньюс телевизийн албан ёсны твиттер хуудас @Eaglenewssocial – г дуурайлгасан хуурамч хаяг юм. Жинхэнэ эзэд нь дээрх хуурамч хоёр хаягийн талаар Твиттерт гомдол гаргаж устгуулсан.

Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглосон. Мөн иргэний дүрс буюу зургийг зөвшөөрөлгүй ашигласан, олон нийтэд үзүүлснээс гэм хор учруулсан бол гэм хорыг арилгах үүрэгтэй. Өнөө цагт Монголд тухайн хаяг хуурамч байх магадлалтай байхад түүнтэй харилцах, хувийн мэдээллээ өгөх зэргээр хохирч байгаа нь хүмүүсийн хайхрамжгүй байдалтай холбоотой байна.

Твиттер дэх хуурамч хаягуудыг таних хэд хэдэн арга бий. Түүнээс товч танилцуулъя. Хуурамч хаягууд өндөгний зурагтай буюу зураггүй байдаг. Бусад вэб сайт дээр нийтэлсэн гэрэл зургийг хувийн зураг болгон нийтэлсэн байдаг. Хуурамч хаягуудад танилцуулга /намтрын/ мэдээлэл байдаггүй. Нэг бичлэг буюу жиргээг хэд хэдэн удаа давтсан байдаг. Энэ нь бусад хэрэглэгч рүү хариу бичих хэлбэрээр давтсан шинжтэй байна. Дэлгэцийн нэр болон URL буюу хаягийн холбоос дээрх нэр нь огт хамааралгүй байдаг. Замбараагүй, утга авцалдаагүй бичвэр-жиргээг нийтэлсэн байх нь элбэг. Идэвхгүй буюу бичвэр оруулаагүй олон жил болсон байдаг. Хэрэглэгчийг дагах боломжтой тооны хязгаарт хүрсэн байх нь бий /Твиттерт бусад хэрэглэгчийг дагах тооны хязгаарыг 2000 гэж тогтоосон. Энэ нь бусад хэрэглэгч таныг эргэн дагасан үед өсөх боломжтой/. Бусад хэрэглэгчтэй огт харилцаагүй байдаг. Дагагчгүй

буюу маш цөөн дагагчтай байна /Дагасан хүнийх нь тоо олон хэдий ч өөрийг нь дагасан хүн байхгүй буюу маш цөөн байгаагаар үүнийг тодорхойлж болно/. Бодит бус буюу маш их хэмжээгээр бичвэр-жиргээ нийтэлсэн байдаг.


Харин фэйсбүүкийн хувьд дунджаар 5-10% буюу ойролцоогоор 140 сая хуурамч хаяг байдаг. 2012 оноос эхлэн эдгээр хуурамч хаягийг устгаж эхэлсэн. Ийм хуурамч хаягийг фэйсбүүкт мэдэгдэх буюу устгуулах тохиргоо бий. Фэйсбүүк дээрх хаягийг жинхэнэ, эсэхийг мэдэхийн тулд түүний найзууд, бичлэг, зургийг сайтар анхаарч шалгах хэрэгтэй. Мөн тань руу бичсэн зурвас нь этгээд, эвгүйцэм байгаа тохиолдолд тийм хаяг хуурамч буюу хүний нэр, зураг ашигласан байх магадлалтай.

Бидний өдөр тутмын хэрэглээ болж, ихээхэн цагаа зарцуулах болсон фэйсбүүк, твиттерт төрөл бүрийн санаа, зорилгоор үүсгэсэн хуурамч хаягууд олноор байдаг, цаашид ч алга болохгүй бөгөөд ийм хуурамч хаягуудаас буруу мэдээлэл авах, хувийн мэдээллээ алдах, нэр төрөө гутаалгах эрсдэлээс өөрийгөө хамгаалахын тулд жинхэнэ, бодит хаягийг дагах буюу нэгдэж байх нь зүйтэй.

## 5.2 ТАНЫ ЗААВАЛ МЭДЭХ ЁСТОЙ ФЭЙСБҮҮКИЙН ТОХИРГООНУУД

2004 онд Харвардын оюутнуудад зориулан бүтээсэн Фэйсбүүк хэмээх сайт удалгүй Бостон орчмын болон Станфордын их сургуулийн оюутнуудын дунд хэрэглэгдэх болж, улмаар 2006 оноос 13-аас дээш настай хэн бүхний нэвтрэх боломжтой нийтийн сүлжээ сайт болон хувирчээ. Олон нийтэд нээлттэй болоод 10 дахь жилийнхээ ойтой золгож буй Фэйсбүүк өдгөө 1.7 тэрбум хэрэглэгчтэй, дэлхийн хамгийн том, нөлөө бүхий сайт болжээ. Хэрэглэгчид бид энэ сайт дээр найз нөхөд, ах дүүтэйгээ холбогдож, бүх л зүйлсийн талаар мэдээлэл авахын сацуу үзэл бодлоо илэрхийлэн өөрийгөө бусдад таниулж, хийж буй ажлаа сурталчилж, бизнесээ өргөжүүлж байна. Тэгвэл бид фэйсбүүкийг үр дүнтэй, зүй зохистой хэрэглэж чаддаг уу?


### «Нууц» инбок




Хэрвээ та энэ цэсийг мэддэггүй бол огт уншаагүй мессеж олноороо цугларсан байх магадлалтай. Энэ бол «MessageRequests» юм. Тантай

фэйсбүүк дээр холбогдоогүй хүнээс ирсэн мессежүүд тэнд ордог. Тэдгээр мессежийг уншихын тулд хуудасны зүүн буланд байх «Messages» рүүгээ ороод «Recent» цэсний дэргэд буй «MessageRequest»-ийг дараарай.

## Таны хаягаар та л нэвтрэх ёстой




Таны зөвшөөрөлгүйгээр хэн нэгэн фэйсбүүкээр тань нэвтэрчихсэн байгаа юм биш биз? Санаатай болон санаандгүйгээр энэ асуудал бидний заримд тохиолдох нь бий. Тэгвэл үүнийг шалгаж нягтлахын тулд Settings>Securityруу ороорой. Тэнд «WhereYou'reLoggedIn» гэсэн хэсэг байгааг та олж харах болно. Энд таны фэйсбүүкт одоо нэвтэрсэн байгаа компьютер, гар утас зэрэг төхөөрөмж, байршил, браузер зэргийн мэдээлэл гарч ирнэ. Хэрвээ таны нэвтрээгүй сэжигтэй төхөөрмөж гарч ирвэл «endactivity» товчийг дарж фэйсбүүкээс салгаарай. Үүнийг найз нөхдийнхөө компьютерээс фэйсбүүкт ороод «logout» дарж гарахаа мартсан үед бас ашиглаж болно.



## Фэйсбүүкийг “өвлүүлж” болно

Хүн бүр цаг нь болохоор насан эцэслэдэг нь хорвоогийн жам. Энэ үнэнтэй хэн ч маргашгүй тул фэйсбүүк ч бас a legacy contact гэсэн ойлголтыг гаргаж иржээ. Хэн нэгэнд золгүй явдал тохиолдож өөд боллоо гэхэд түүний итгэлтэй хүн нь фэйсбүүк хаягийг нь хариуцан, ажиллуулах болно. **Legacy contact**-ийг ашиглан урьдчилан сонгох энэ хүн акаунт дээр нь пост бичиж, найзын хүсэлтэд хариу өгч, профайл болон толгой зургийг сольж чадна. Харин мессеж, чатны түүхийг нь уншиж чадахгүй(Гэхдээ зөвшөөрвөл болно).

Энэ хүнийг **Settings > Security > Legacy Contact tab** гэж ороод сонгоорой. Мөн фэйсбүүк хаягаа устгуулах сонголтыг ч урьдчилаад хийх боломжтой юм.



## Хүссэн сурталчилгаагаа л үзье

Фэйсбүүк дээрх сурталчилгаанууд бол урилгагүй зочдын нэг. Гэвч та сурталчилгааг «урилгатай» болгох буюу өөрийн дуртай зүйлстэй холбогдсон сурталчилгаануудыг үзэх боломжтой болгож болно. Товчхондоо ямар сурталчилгаа харахаа өөрөө сонгоно гэсэн үг. Ингэхийн тулд **Settings > Ads** рүү ороод «**Ads based on my preferences**» цэсийн дэргэд байх edit товчийг дараарай. Эндээс Фэйсбүүк таны дуртай зүйлсийг юу юу гэж тодорхойлсныг харж болно. Тэд таны **like** дарсан хүмүүс, брэндүүд, компаниудаас үүдэн тохирох сэдвүүдийг зааж өгсөн байдаг. Эдгээрээс та устгахыг нь устгаж эсвэл нэмсэн ч болно.



## 5.3 ИНТЕРНЭТЭД ХЭРХЭН ҮНЭГҮЙ ХОЛБОГДОХ ВЭ?

- Freebasic үйлчилгээ гэж юу бэ.Хэрхэн төлбөргүй интернэт хэрэглэх вэ?
- Free basics үйлчилгээ

Мобиком Корпораци Facebook-тэй хамтран интернэтийг илүү олон хэрэглэгчид хүргэх зорилгоор Free Basics үйлчилгээг нэвтрүүлсэн. Ингэснээр Мобикомын хэрэглэгчид Free Basics үйлчилгээг ашиглан гар утаснаасаа өргөн хэрэглээнд зориулсан боловсрол, эрүүл мэнд, мэдээний болон олон нийтийн сүлжээний тодорхой тооны вэб сайтуудад үнэ төлбөргүйгээр хандах боломжтой юм. Free Basics нь интернэтийн үндсэн хэрэглээг түгээх зорилготой үйлчилгээ бөгөөд таны хандсан вэб сайтуудын мэдээллийг зөвхөн текст хэлбэрээр харуулна. Зураг болон бусад мэдээлэл рүү хандахад датаны төлбөр тооцогдохыг анхаарна уу.

### Ашиглах заавар:






- [freebasics.com](http://freebasics.com) хуудсанд шууд хандах боломжтой



- Андроид үйлдлийн систем бүхий гар утастай бол free basics аппликейшныг татна уу.



- iOS үйлдлийн систем бүхий гар утастай хэрэглэгчид зөвхөн Интернэт хөтөч буюу Safari ашиглана уу.



**Санамж:** Free Basics үйлчилгээ нь гар утасны марк, үйлдлийн систем болон бусад аппликейшны тохиргооноос хамааран дата тооцогдож болзошгүйг анхаарна уу.

Freebasics үйлчилгээ нь дараах сайтуудад үнэ төлбөргүй хандана.

Үүнд:

№	НЭР	№	НЭР
1	Gogo мэдээ	15	Money Matters
2	Gogo зурхай	16	Girl Effect
3	Gogo хөтөлбөр	17	SmartBusiness
4	Gogo цаг агаар	18	SmartWoman
5	Gogo валютын ханш	19	Socialblood
6	24symbols	20	Translate.com
7	AccuWeather	21	Thesaurus.com
8	Ask.com	22	Facts for Life
9	Bing	23	U-Report
10	MAMA	24	Wattpad
11	Connect Smart	25	wikiHow
12	Dictionary.com	26	Wikipedia
13	Facebook	27	Worldreader
14	Messenger	28	Your money

Дэлгэрэнгүй мэдээллийг Мобикомын лавлах 2222 болон бусад операторын хэрэглэгчид 1800-2222 дугаараас авна уу.

## VI. ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН УТАС 108



Хүүхдийн төлөө үндэсний газар, Мобиком корпораци, Дэлхий зөн ОУБ хамтран хүүхдийн эрхийг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн

эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүчирхийллийн талаар бодитой мэдээлэл судалгааны санг хөгжүүлэх зорилгоор Хүүхдийн тусламжийн утсыг 108 дугаартайгаар ажиллуулж байна.

Тусламж, мэдээлэл шаардлагатай байгаа хүүхэд бүр Хүүхдийн тусламжийн утас 108 дугаарт Монгол Улсын хаанаас ч 24 цагийн турш, үнэ төлбөргүй холбогдох боломжтой бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй тусламжийн баг дараах зарчмыг баримтлан таны хүүхдийн төлөө ажиллаж байна. Үүнд:



- Хүссэн мэдээлэгч дуудлагаа үнэ төлбөргүй хийх
- 24 цагийн турш ажиллах
- Хүүхэд тогтооход хялбар дугаартай байх
- Монгол Улсын өнцөг булан бүрээс холбогдох боломжтой
- Дуудлага бүрийг хүлээн авч, хариу өгөх, шаардлагатай бусад үйлчилгээнд холбох (Эмнэлэг, цагдаа гэх мэт)
- Дуудлага бүрийн дагуу хүүхдэд шаардлагатай үйлчилгээг түргэн шуурхай, шат дамжлага багатайгаар хүргэх
- Хамтарсан багт түшиглэсэн байх
- Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг чанд хадгалах

## VII. ЯАЖ.МН ХАЙЛТЫН СИСТЕМИЙН ТУХАЙ



Яаж.мн нь Монгол Улсын иргэдийн цахим боловсролыг дээшлүүлэх, тоон бичиг үсэгтэнг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас санаачлан, эрхэлж буй цахим хуудас юм.

Уг хуудаснаас та цахим тоног төхөөрөмж, програм хангамж, интернэт хэрэглээ, ухаалаг гар утас болон төхөөрөмжүүд, тэдгээрийг хэрхэн ашиглах тухай зөвлөгөө, бидний өдөр тутмын

амьдралд ашиглагддаг мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын бүхий л бараа, бүтээгдэхүүний заавар, зөвлөгөөг авахаас гадна цахим орчинд аюулгүй, найдвартай, хурдан, үр дүнтэй ажиллаж, амьдрах цахим боловсролыг олно. Өөрөөр хэлбэл, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаарх таны ЯАЖ? гэсэн бүхасуултанд бидхариулах болно.



## VIII. ТООН ГАРЫН ҮСГИЙН ХЭРЭГЛЭЭ

Цахим гэрээ хэлцэл. Улс хооронд эсвэл орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахим баримт бичиг солилцох, гэрээ хэлцэл хийхдээ тоон гарын үсгийг ашиглах нь бизнесийн харилцааны найдвартай хэрэгсэл болно. Гэрээ, хэлцлийн цахим баримт бичиг солилцохдоо тоон гарын үсгээр баталгаажуулах нь тухайн баримт бичигт өөрчлөлт орсон, эсэхийг бүрэн тодорхойлох боломжтой.

Цахим худалдаа, худалдан авалт. Төрийн болон бизнесийн байгууллагууд худалдан авалт, тендер зохион байгуулах ажиллагааг цахим хэлбэрээр гүйцэтгэж, цахим гэрээг тоон гарын үсэг зурж шууд илгээдэг, байгуулдаг болсон. Энэ нь худалдан авах үйл ажиллагааг шуурхай болгохоос гадна авлигатай тэмцэх, цахим орчинд залилан мэхлэх гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх хүчирхэг хэрэгсэл гэж тооцогдож байна.

Төрийн үйлчилгээ. Дэлхийн улсуудын цахим засгийн онлайн үйлчилгээнд хандах, үйлчлүүлэхдээ иргэд өөрсдийн тоон гарын үсгээ (иргэний үнэмлэх юмуу, крипто токенд агуулсан) ашиглах явдал түгээмэл болсон. Иргэд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах, үйлчилгээний маягт бөглөх, явуулж буй баримтуудаа баталгаажуулахдаа тоон гарын үсгээ ашиглахаас гадна онлайн үйлчилгээний системд хандахдаа тоон гарын үсгээр өөрийгөө таниулж, баталгаажуулдаг. Мөн хариу ирж буй баримт бичиг, үзүүлж буй үйлчилгээ төрийн албан хаагчийн тоон гарын үсгээр баталгаажин ирдэг болсон байна.

Цахим албан хэрэг хөтлөлт. Төр, бизнесийн аливаа байгууллагын гадаад болон дотоод албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа тоон

гарын үсэг ашиглан баталгаат цахим хэлбэрээр эрхэлдэг болсон. Зохион байгуулалт, захиргаа удирдлага, менежмент, хүний нөөц, эрх зүй, худалдаа арилжаа, зураг төсөл, аж ахуйн тайлан, бүртгэл, ня-бо бүртгэлийн гэх мэт бүх төрлийн баримт бичгүүд тоон гарын үсгээр баталгаажиж цахим орчинд эргэлтэнд ордог болсон.

Төрийн байгууллагад гаргаж өгдөг цахим тайлан, мэдээлэл. Дэлхийн улсуудад төрийн захиргааны болон хяналтын байгууллагад гаргаж өгдөг бүх төрлийн тайланг тоон гарын үсэг зурж баталгаажуулах болсноор компани, аж ахуйн нэгжүүдэд хялбар, хямд төсөр болсноос гадна олон байцаагчийн орон тоо багасаж, цаас, хор гэх мэт оффисын зардал хэмнэж, тэр хэрээр улсын төсвийн мөнгийг ихээр хэмнэх болсон.

Бүх төрлийн системд хандахад таньж, баталгаажуулах. Дэлхийн улсуудын төр, бизнесийн байгууллага, банкууд өөрийн мэдээллийн системийн хандалтын удирдлагыг тоон гарын үсэгт суурилан зохион байгуулдаг болсон. Үүний үр дүнд системд хууль бусаар хандах боломжийг бүрэн хааж чадаж байна.

Цахим шүүх, нотариат. Хууль, шүүхийн байгууллагууд дотоод цахим албан хэрэг хөтлөлтөд шилжсэнээс гадна иргэдэд олгох төрөл бүрийн лавлагаа, баримтыг тоон гарын үсэг зурж, цахим хэлбэрээр илгээдэг, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахим хэлбэрээр авдаг болсон. Европ, АНУ, Япон, БНСУ-ын нотариатчид иргэдийн батлуулахыг хүссэн, тоон гарын үсэг зурсан баримт бичиг, гэрээг тоон гарын үсгээрээ баталж, онлайнаар илгээдэг болсон нь мэдээллийн нийгмийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх боломжийг хангасан байна.

## IX. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМ МАШИН



Монгол Улын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах мэдээллийн систем бий болгох” төслийг 2012 оноос эхлэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлж амжилттай дуусгасны нэг нь “Төрийн үйлчилгээний цахим машин” юм.

ТҮЦ машин нь төрийн үйлчилгээг иргэдэд орон даяар жигд хүртээмжтэй, ил тод, авлига, хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэдэг цахим машин юм. Монгол Улсын 21 аймаг болон томоохон сум сууринд 30 ширхэг, Улаанбаатар хотод 77 ширхэг ТҮЦ машин суурьлуулж, үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулж байна.

ТҮЦ машиныг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэд төрийн үйлчилгээг долоо хоногийн 24 цагийн аль ч үед урт дараалал, хүнд сурталгүйгээр өөрт ойр байрлах ТҮЦ машинаас түргэн шуурхай авах боломжтой болсон.

ТҮЦ машины үйлчилгээ нь Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглагддаг QR кодоор баталгаажсан нууцлалтай цаасан дээр хэвлэгддэг тул хуурамчаар үйлдэх, хуулбарлах боломжгүй. Лавлагааны нууцлалтай цаасыг хэт ягаан гэрлийн туяанд харахад соёмбо тэмдэг харагдана.

ТҮЦ машин нь бэлнээр 500, 1000 төгрөгийн дэвсгэрт уншихаас гадна бэлэн бусаар төгрөгийн карт уншуулан төлбөр тооцоо хийнэ. 2013 онд үйлдвэрлэгдсэн 1000 төгрөгийн мөнгөн дэвсгэртийг ТҮЦ машин уншихгүй байгаа асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

ТҮЦ машинаар дамжуулан 16 нэр төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа бөгөөд НӨАТ-ын баримт бүртгүүлэх, данс тохируулах, бүртгэлтэй баримтууд харах үйлчилгээнүүдийг шинээр нэвтрүүлж байна. ТҮЦ машинаас авч болох үйлчилгээнүүд:

1. Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа
2. Жолоодох эрхийн лавлагаа
3. Татварын лавлагаа
4. Хуулийн этгээд бүртгэлгүй лавлагаа
5. Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа
6. Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн лавлагаа
7. Ачааны авто машины зөвшөөрлийн төлбөрийн баримт
8. Төрсний бүртгэлийн лавлагаа
9. Гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа
10. Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа
11. Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа
12. Оршин суугаа хаягийн тодорхойлолт
13. Иргэний үнэмлэхний лавлагаа
14. Нийгмийн даатгал нэрийн данс
15. Нийгмийн даатгал тэтгэвэрийн эрх
16. Нийгмийн даатгал ажил олгогч
17. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт
18. Эрх сэргээх лавлагаа
19. Төрийн үйлчилгээний цахим системд нэвтрэх эрх авах
20. Валютын ханшийн лавлагаа
21. Цахилгааны төлбөр төлөх
22. Ачааны автомашины зөвшөөрөл
23. Данс тохируулах
24. Баримт бүртгүүлэх
25. Бүртгэлтэй баримтууд

## 9.1 ТҮЦ МАШИНААС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЗААВАР

ТА ТӨРСНИЙ БҮРТГЭЛИЙН ЛАВЛАГАА АВАХ БОЛ	
Үйлчилгээг сонгоно	Та дэлгэц дээр байрлах Төрсний бүртгэлийн лавлагаа үйлчилгээг сонгоно
Мэдээллээ оруулах	Та регистрийн дугаараа оруулаад Үргэлжлүүлэх товчийг дарна. Регистрийн дугаар оруулахдаа 4 дугаарын төхөөрөмж дээр байрлах ENGMON товчийг дарж үсгийн фонтоо сольж, MON болгоно.
Хурууны хээг уншуулах	Та 5 дугаартай төхөөрөмжид баруун гарын долоовор хурууны хээг уншуулна. Хэрэв 16 нас хүрээгүй тохиолдолд эхийн хурууны хээг уншуулна.
Таны мэдээллийг шалгаж, дэлгэц дээр харуулах	Түц машин таны мэдээллийг бүртгэж, ОӨУБЕГ-ын мэдээллийн баазтай тулгалт хийж шалгасны дараа таны мэдээллийг дэлгэц дээр харуулна.
Төлбөр төлөх хэлбэрээ сонгох	Та төлбөр хийхдээ кредит карт, бэлэн мөнгө гэсэн сонголтуудаас сонгоно. <b>Төлбөрөө бэлэн мөнгөөр хийх</b> Та бэлэн мөнгө гэсэн сонголтыг сонгосон бол 9 дугаартай төхөөрөмжид үйлчилгээний хураамж болох 500/1000 төгрөгийг хийнэ. <b>Төлбөрөө кредит картаар хийх</b> Та кредит карт гэсэн сонголтыг сонгосон бол 2 дугаарын төхөөрөмжид картыг дээш харуулж хийнэ.
Төлбөрийн баримтаа авах	Та төлбөрийн баримт авах уу? √ Тийм, x Үгүй гэсэн сонголтуудаас сонгоно.
Лавлагаагаа авах	Та 10 дугаартай төхөөрөмжөөс өөрийн тодорхойлолт, лавлагааг авна.



*2016 оны 3-р улирлын байдлаар ТҮЦ машинаар авсан үйлчилгээний тоон мэдээлэл*

Үйлчилгээний төрөл	Тоогоор	Хувиар
Иргэний үнэмлэхний лавлагаа	157292	51.24%
Оршин суугаа хаягийн лавлагаа	58584	19.09%
Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа	20839	6.79%
Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	20711	6.75%
Гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа	17851	5.82%
Төрсний бүртгэлийн лавлагаа	9725	3.17%
Ачааны автомашины зөвшөөрөл	9550	3.11%
Жолоодох эрхийн лавлагаа	7197	2.34%
Цахилгааны төлбөр төлөх	1123	0.37%
Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн лавлагаа	1039	0.34%
Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа	938	0.31%
Ачааны автомашины зөвшөөрлийн баримт авах	689	0.22%
Төрийн үйлчилгээний цахим системд нэвтрэх эрх авах	616	0.2%
Хуулийн этгээдийн бүртгэлгүй лавлагаа	527	0.17%
Татварын лавлагаа	150	0.05%
Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа	111	0.03%
Эрх сэргээх лавлагаа	21	0.01%
Нийт	306852	

*2014 оноос хойш давхардсан тоогоор 3146375 үйлчилгээг иргэд ТҮЦ машинаар дамжуулан авсан байна.*



**ТҮЦ машин хэрэглээнд нэвтэрснээр дараах дэвшилт гарсан**

1. Иргэнд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэж, иргэдийн бухимдлыг бодитоор бууруулсан.
2. Түргэн шуурхай үйлчилгээ хүргэдэг болсноор иргэний цаг, мөнгийг хэмнэдэг.
3. Иргэн өөрт хамгийн ойр байрлах ТҮЦ машинаас төрийн үйлчилгээг 24 цагаар, ажлын өдөр харгалзахгүй авдаг болсон.
4. Иргэний цахим үнэмлэхийг өдөр тутмын хэрэглээнд бүрэн оруулсан.

**ТҮЦ машины байршил**

1. ХУД Яармаг Гадаадын Иргэний Харьяатын асуудал эрхэлсэн газар
2. СБД 100 айлын Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
3. ЧД “Тэнгис” кино театр
4. СБД Мэдээлэл технологийн үндэсний парк
5. ХУД 19-ийн Үйлчилгээний төв
6. БГД “Апекс” худалдааны төв
7. ЧД 32-ын тойрог “Номин” их дэлгүүр
8. ЧД “Улаанбаатар” банк
9. ЧД 7-н буудлын “Бүрэн” плаза
10. ХУД “Чингис хаан” ОУНОБ
11. БЗД Нийслэлийн Улсын бүртгэлийн хэлтэс
12. СХД ЗДТГ
13. ЧД TEDY-2 Skytel салбар
14. СХД “Хархорин” зах, Заан барилгын материал худалдааны төв
15. ЧД Төв шуудан
16. СБД Skytel plaza
17. БГД Төмөр замын төв буудал
18. БГД “Москва” их дэлгүүр
19. СБД 1 дүгээр төрөх эмнэлэг
20. ХУД Замын цагдаа
21. ЧД Улсын их дэлгүүр
22. БЗД Сансарын “Капитал” банк
23. ЧД “Тэди” төв
24. ЧД Төв шуудан
25. ЧД Дэнжийн-1000 “Дөрвөн шонхор” худалдааны төв
26. СХД 21 Худалдааны төв
27. БГД “Оргил” худалдааны төв
28. СХД “Цамбагарав”-ын арын замд Замын Цагдаа
29. БГД 3 дугаар эмнэлэгийн “Ариг” банк
30. ХУД Хоум Плаза 2
31. БГД Баруун 4 зам “Гранд Плаза”
32. БЗД ЗДТГ
33. СБД Худалдан авах ажиллагааны газар
34. СБД ЗДТГ
35. СБД, 1 дүгээр эмнэлэг
36. СБД 32-ын тойрог “Бүрд” төв
37. СБД Дамбадаржаа “Наран” төв
38. БЗД Дарь-Эх 27-р хорооны байр
39. ХУД Яармаг БОСА төв
40. БГД Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв
41. СБД 100 айл ОӨУБЕГ-ын 1-р байр
42. БЗД “Жуков” Худалдааны Төв
43. БЗД ЗДТГ
44. БГД Мэргэжилтний 20, “Ариг” банк
45. СХД “Драгон” төв
46. БЗД Гачуурт Дэлгүүр 1
47. БЗД, “Улиастай” Худалдааны Төв
48. ХУД-ТЭЦ-4
49. БЗД 13 дугаар хорооллын “Ариг” банк
50. БЗД, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
51. ЧД ЗДТГ
52. БЗД, “Скай” Худалдааны Төв
53. СХД Баянхошуу “Нархан”
54. БГД Баянгол дүүргийн

- шүүхийн байрны хажууд
55. СХД Баянхошуу БОСА төв
  56. СХД 21 дүгээр хороолол “Макс” төв
  57. БЗД “Тэнгэр” худалдааны төв
  58. ЧД 40 мянгатын “Ариг” банк
  59. СХД “Цамбагарав”-ын “Макс” супермаркет
  60. СХД ЗДТГ
  61. БГД “Махmall” супермаркет
  62. БЗД Цагдаагийн Лицензийн төв
  63. ХУД “Яармаг” худалааны төв
  64. БГДЗДТГ
  65. БЗД “Дүнжингарав” худалдааны төвийн Нэг цэгийн үйлчилгээ
  66. БЗД Да хүрээ “Дөрвөнөлзий” автоплаза
  67. ХУД УБ цахилгаан түгээх сүлжээ
  68. БГД 10 дугаар хороолол EFES төв
  69. СХД Таван шарын “Энхжин” худалдааны төв
  70. БЗД Ботаник Well mart худалдааны төв
  71. БЗД Цайз 16 Well mart худалдааны төв
  72. БЗД “Дүнжингарав” худалдааны төв
  73. ХУД “Жетро” худалдааны төв
  74. БЗД, “Амгалан” зах
  75. ХУД “Вива Сити”
  76. СБД Төрийн Ордон
  77. Ховд
  78. Баянхонгор
  79. Говь-Алтай
  80. Баян-Өлгий
  81. Өвөрхангай
  82. Хөвсгөл
  83. Завхан
  84. Архангай
  85. Увс
  86. Дорноговь
  87. Сэлэнгэ
  88. Хуучин Дархан
  89. Говьсүмбэр
  90. Дундговь
  91. Өмнөговь
  92. Төв
  93. Сүхбаатар
  94. Налайх
  95. Дорнод
  96. Замын-Үүд
  97. Шинэ Дархан
  98. Эрдэнэт
  99. Хэнтий
  100. Булган
  101. Архангай ИТ
  102. Багануур
  103. Зүүнхараа
  104. Сэлэнгэ аймаг Хөтөл
  105. Эрдэнэт ЗДТГ
  106. Эрдэнэт Хорооллын Эцэс Багийн нэгдсэн байр

## Х. ДЭЛГЭЦИЙН ГЭРЛИЙН ХОР УРШИГ



Гэрэл цахилгаан бүтээх хүртэл гэрэлтүүлгийн гол эх үүсвэр нь нар байсан бөгөөд хүмүүс оройг харанхуйд өнгөрөөдөг байжээ. Гэтэл одоо унтах хүртлээ бид гэрэлтэй орчинд байх боломжтой болсон. Энэхүү давуу талаа бид бараг анзаарахаа больжээ. Гэхдээ гэрэлтэйд өнгөрөөдөг энэ их цагаа бид эрүүл мэндээрээ төлж байна гэвэл та итгэх үү? Шөнийн цагаар гэрэлд байх нь хүний биоритмийг гажуудуулдаг. Нойронд өөрчлөлт оруулдаг. Зарим судалгаагаар хавдар, чихрийн шижин, зүрх судасны өвчин, таргалалтанд ч нөлөөлж байгаа нь тогтоогдсон байна. Гэхдээ бүх гэрэл адилхан нөлөөлдөггүй. Хамгийн их нөлөөтэй нь цэнхэр долгион байдаг байна. Энэ нь анхаарлыг сайжруулж, хариу үйлдэл үзүүлэх хугацаа, сэтгэл хөдлөлд сайнаар нөлөөлдөг тул өдрийн цагаар ач тустай ч шөнө хамгийн сөрөг нөлөөтэй юм. Бид том дэлгэцтэй зурагтүзэж, эрчим хүчинд хэмнэлттэй гэрэл ашиглах нь цэнхэр гэрэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

### Гэрлээс хамааралтай хоногийн ритм

Хүн бүрийн хоногийн ритм ялгаатай ч дундаж нь 24.3 цаг байдаг. Оройтож унтдаг хүмүүсийн ритм үүнээс арай урт байдаг бол эртэч шувуухайнуудынх 24 цагаас бага байдаг. 1981 онд Харвардын Анагаах Ухааны Сургуулийн доктор Чарльз Чейзлерийн тогтоосноор нарны гэрэл нь хүний дотоод цаг буюу биоритмийг орчин тойронтой уялдуулдаг гэнэ.

### Шөнийн гэрлээс үүдэх өвчлөл

Шөнийн ээлжинд ажиллах, шөнө гэрэлтэйд тогтмол байх нь олон төрлийн хавдар, чихрийн шижин, зүрхний өвчин, таргалалттай холбоотойг баталсан судалгаа олон бий. Гэрэлд байх нь хоногийн ритмд нөлөөлдөг даавар болох мелатонины ялгарлыг дарангуйлдаг ба мелатонины хэмжээ бага байх нь хавдар үүсгэх магадлалтай.

Харвардын нойрны судлаач Стефен Локлигийн үзэж буйгаар маш бага хэмжээний гэрэл ч (ширээний чийдэнгийн гэрлээс бага зэрэг илүү) хүний ритм, мелатонины ялгаралд нөлөөлдөг байна. Олон хүмүүс хангалттай нойрсож чаддаггүйн нэг шалтгаан нь шөнө гэрэлтэй орчинд байх бөгөөд нойр хангалтгүй байх нь сэтгэл гутрал, чихрийн шижин, зүрх судасны өвчтэй холбоотойг Локли болон бусад судлаачид хэлж байна.


Бүх төрлийн гэрэл мелатонины ялгарлыг дарангуйлах ч хамгийн хүчтэй нөлөөтэй нь цэнхэр гэрэл. Ижил хэмжээний гэрэлтүүлэгтэй цэнхэр болон ногоон гэрлийг харьцуулж, 6.5 цагийн өртөлтийн нөлөөг хэмжихэд цэнхэр гэрэл нь мелатонины ялгарлыг хоёр дахин илүү дарангуйлж, хоногийн ритмийг илүү өөрчилж (гурван цаг болон 1.5 цагаар) байсан судалгааг Харвардын судлаачид хийжээ.

Торонтогийн их сургуулийн судлаачдын хийсэн бас нэгэн судалгаагаар хурц гэрэлтэйд цэнхэр гэрлээс хамгаалах шил зүүсэн болон ердийн гэрэлд шилгүй байсан хүмүүсийн мелатонины түвшинг харьцуулжээ. Хоёр бүлгийн дааврын хэмжээ ижил түвшинд байсан нь цэнхэр гэрэл мелатониныг бодитой дарангуйлагч гэдгийг баталсан юм. Мөн шөнийн ээлжнийхэн, эсвэл шөнө унтдаггүй “шар шувуу”-нууд цэнхэр гэрлийг хаадаг нүдний шил зүүснээр өөрийгөө хамгаалж болох магадлалтайг харуулжээ. Улбар шар өнгөтэй, өндөр үнэтэй биш шил цэнхэр гэрлийг хаах боловч бусад өнгийг ч гэсэн хаадаг тул тасалгаанд зүүхэд тохиромжгүй.

### Гэрлээс үүдэх өвчлөлөөс өөрийгөө хамгаалах аргаас

- Шөнийн гэрэлтүүлэгт бүдэг, улаан гэрлийг ашигла. Улаан гэрэл нь хоногийн ритмд нөлөөлөх, мелатониныг дарангуйлах нь хамгийн бага байдаг гэрэл юм.
- Орондоо орохоос 2-3 цагийн өмнөөс хурц гэрэлтэй дэлгэц ширтэхээс зайлсхий.
- Хэрэв та шөнийн ээлжинд ажилладаг эсвэл шөнө цахилгаан хэрэгсэл их ашигладаг бол цэнхэр гэрлээс хамгаалдаг шил хэрэглээрэй.
- Өдрийн цагаар хурц гэрэлтэй орчинд удаан байснаар шөнө унтах чадвараа сайжруулахаас гадна өдрийн цагаар сэргэг, сэргэлэн цовоо байх болно.

## АЛДСАН ANDROID ТӨХӨӨРӨМЖӨӨ ХАЙХ, ТҮГЖИХ, ӨГӨГДЛӨӨ УСТГАХ




Google компанийн гаргасан *Find My Device* нь гэсэн эсвэл хулгайлагдсан гар утас болон таблетуудыг олоход тусалдаг. Энэ үйлчилгээг бид вэб болон аппликэйшн хувилбараар авч болно. *Find My Device* аппликэйшн нь *Lookout*, Samsung компанийн гаргасан *Find My Mobile* зэрэг байршил тодорхойлох бусад үйлчилгээнүүдтэй ижил боловч Android төхөөрөмжүүдэд онцгойлон зориулсан аппликэйшн юм. *Find My Device* хэрхэн ашиглах талаар авч үзье.

## Төхөөрөмжийн тохиргоог идэвхжүүлэх

*Find My Device* ашиглахын тулд Google эрхээрээ (Gmail эрх) нэвтэрч орсон, интернэтэд холбогдсон, утсан дээрх *location* буюу байршил тодорхойлох шинж чанар болон *Find My Device* шинж чанарыг тус тус идэвхжүүлсэн, *Google Play* дээр тухайн төхөөрөмж харагдаж байх хэрэгтэй.

**Алхам 1: Таны төхөөрөмжид *Find My Device* шинж чанарыг идэвхжүүлсэн эсэхийг шалгах. Хэрвээ энэ нь идэвхжээгүй бол та дараах тохиргоог хийнэ.**


- Төхөөрөмжийн **Settings**  аппликэйшныг нээнэ.
- **Security & Location** сонго. Хэрэв “Security & Location” гэж утсан дээр харагдахгүй бол **Google->Security** дээр дарна.
- **Find My Device** сонго.
- **Remotely locate this device** болон **Allow remote lock and erase** сонголтуудыг идэвхжүүлнэ.

**Алхам 2: Location идэвхжсэн эсэхийг шалгах**

- Төхөөрөмжийн **Settings**  аппликэйшныг нээнэ.
- **Security & Location** сонго. Хэрэв “Security & Location” гэж утсан дээр харагдахгүй бол **Google->Security** дээр дарна.
- **Location** идэвхжүүлнэ.

**Алхам 3: *Google Play* дээр төхөөрөмж харагдаж байгаа эсэхийг шалгах**  
Хэрвээ *Google Play* дээр таны төхөөрөмж харагдахгүй байвал энэ нь *Find My Device*-д мөн харагдахгүй. Төхөөрөмжийг харуулахын тулд дараах тохиргоог хийнэ.

- [play.google.com/settings](https://play.google.com/settings) холбоосыг нээнэ.
- “*Visibility*” болгох төхөөрөмжөө сонго.



NICKNAME	VISIBILITY	MAKER	MODEL	CARRIER	LAST USED
 Unnamed Device	<input checked="" type="checkbox"/> Show in menus	Samsung	SM-J500H	Mobicom	November 10, 2017

**Алхам 4: Та өөрийн төхөөрөмжийг хайж, олж байгаа эсэхийг шалгах**


- [android.com/find](https://android.com/find) холбоосыг нээж, өөрийн *Google* эрхээр (*Gmail* эрхээр) нэвтэрч орно.
- Хэрвээ танд нэгээс олон төхөөрөмж байгаа бол дэлгэцийн дээд хэсэгт тухайн нэг төхөөрөмж дээр дарна.
- Таны төхөөрөмжийн байрлалын мэдээлэл газрын зураг дээр харагдах ба *Play Sound, Lock, Erase Device* гэсэн сонголтууд гарч ирнэ. Вэб хувилбар дээр гарах эдгээр сонголтуудын тайлбарыг *Find My Device* аппликэйшн хувилбар дээр тайлбарлана.

## Find My Device аппликэйшныг суулгах

Гар утас, таблет гэх мэт төхөөрөмжийн *Play Store*-руу орж, *Find My Device* аппликэйшныг суулгана. Ижил нэртэй хэд хэдэн аппликэйшн байгаа тул гарч ирэх жагсаалтаас тухайн аппликэйшны хөгжүүлэгч нь “Google Inc.” байгаа эсэхийг шалган, түүнийг сонгоно. Үүний дараа Google эрхээрээ (Gmail эрх) нэвтэрч орно. Таны байршлын өгөгдлийг ашиглахыг хүссэн зөвшөөрлийг асууна. Үргэлжлүүлэхийн тулд **Accept** дарна. Та нэвтэрч орсоны дараа хяналтын самбар таны утсыг хаана байгааг харуулах ба дараах хэд хэдэн сонголтууд мөн гарч ирнэ.




**Location:** Таны андройд төхөөрөмжийн байрлал газрын зураг дээр автоматаар харагдах ба төхөөрөмжийн батарейн хувь, таны утас онлайн байгаа эсэх, хамгийн сүүлд хэзээ төхөөрөмжийн байрлалыг харсан мэдээллүүдийг хамт гаргана. Та байрлалаа шалгахын тулд газрын зургийг томруулж, жижигрүүлж болно.




**Play Sound:** Location буюу байршлын өгөгдөл нь ойролцоогоор гаргадаг ба төхөөрөмж нь таны гэрийн хаа нэгтээ нуугдсаныг дүрсэлж харуулах боломжгүй. Та утсаа олохын тулд хэн нэгнээр утас руугаа залгуулахын оронд **Play Sound** сонголтыг дарснаар аппликэйшнаас таны төхөөрөмж рүү дуудлага хийж болно. Ингэснээр төхөөрөмжийн дууг хаасан эсвэл

чичиргээн дээр нь тавьсан үед ч дууны түвшний хамгийн өндөр утган дээр 5 минутын турш дуудлага хийнэ. Дуудлагыг зогсоохын тулд таны утсан дээрх *power* товч дээр дарна.



**Lock:** Хэрвээ та андройд төхөөрөмжөө түгжихийг хүсвэл энэ сонголт нь танд тусална. Үүнийг хийснээр та алдсан төхөөрөмжөө олж авахыг оролдох хугацаанд хэн ч таны өгөгдөлд хандаж чадахгүй болно. Төхөөрөмжийг түгжихийн тулд *Lock* сонголт дээр дарна. Та шинэ нууц үгээ 2 удаа оруулж, таны утсыг олсон хэн нэгэнд зориулж

тантай холбоо барих утасны дугаарыг оруулж, *Lock* товчийг дарна. Таны төхөөрөмж рүү команд илгээгдсэний дараа төхөөрөмжийг хэрэглэж байсан ч тэр даруй түгжигдэнэ.




**Erase Device:** Хэрвээ та төхөөрөмжөө алдчихсан, хувийн өгөгдлүүдээ хамгаалахыг хүсвэл төхөөрөмжийг үйлдвэрээс ирэхэд байсан анхны төлөвт шилжүүлэх **Erase** сонголтыг сонгоно. Ингэснээр таны суулгасан бүх аппликэйшн, зураг, хөгжим мөн төхөөрөмжид хийсэн бүх тохиргоонууд бүгд устана. Хэрвээ устгах командыг илгээх үед таны төхөөрөмж интернэтэд холбогдоогүй бол төхөөрөмж интернэтэд холбогдох тэр үед энэ үйлдэл нь хийгдэнэ. Та

төхөөрөмжийн бүх мэдээллийг арилгасан бол аппликэйшнаас уг төхөөрөмж рүү удаан хандах боломжгүй. Мөн энэ командаар төхөөрөмжид нэмэлтээр суусан SD санах ойн картны өгөгдөл устахгүй байж болно гэдгийг анхаарна уу. Хэрвээ таны төхөөрөмж хулгайлагдсан бол та цагдаад мэдэгдэж, тэдэнд түүнийг олох ажлыг даатгаарай. Харин *Find My Device* аппликэйшнтэй байгаа үед таны өгөгдөл аюулгүй байх боломжтой юм.

## GOOGLE ДЭЭР ЗУРГААР ХЭРХЭН ХАЙЛТ ХИЙХ ВЭ?


Google хайлтын системийг ашиглан бид ихэвчлэн текстээр хайлт хийдэг. Тухайн тексттэй холбоотой илэрцүүд нь бидэнд зургаар, видео, мэдээ гэх мэт хэлбэрүүдээр гарч ирдэг.




Тэгвэл текстээр биш бидэнд байгаа зургийг ашиглан хайлт хийх боломжтой. Та компьютераасаа Google-ийн зурган хайлтыг ашиглан хайлт хийх, эсвэл компьютер болон гар утаснаасаа Google Chrome вэб хөтчийг ашиглан онлайн зургуудыг хайх боломжтой. Зургаар хайлт хийх дараах 3 аргыг авч үзье.

## Компьютераас Google-н хайлтыг ашиглах


**1. Google images** вэб хуудсыг нээх. Вэб хөтчийн хаягийн мөрөнд <https://images.google.com/> хаягийг бичнэ.




2.  товч дээр дарах. Хэрвээ та тодорхой үг эсвэл хэлцтэй тэнцүү байх зургийг хайхыг хүсвэл хайлтын мөрөнд тухайн үгээ бичиж, **↵Enter** товч дээр дарснаар зурган үр дүнгүүдийг харах болно. Зураг оруулж, хайлт хийхийг хүсвэл хуудасны голд байрлах хайлтын мөрний баруун талд орших камерны дүрс бүхий Search by image товч дээр дарна.



3. Зураг байрлуулах сонголтыг сонгох. Дараах табуудын нэгийг сонгоно.
- *Paste image URL*: энэ табыг сонгон, зургийн вэб хаягийг хуулна. Зургийн вэб хаягийг хуулахын тулд зургийг нээж, цонхны дээр байрлах хаягийн мөр дээр хулганаар дарж, **Ctrl+C** (Windows) эсвэл **⌘ Command+C** (Mac) товчны хослолыг дарна.
  - *Upload an image*: Таны компьютер дээр хадгалагдаж буй зургийг ашиглахыг хүсвэл энэ табыг сонгоно.




4. Зургаа байршуулах. Зургийг байршуулах таны сонголтоос шалтгаалан энэ алхам нь өөр байж болно.
- *Paste image URL* – хайлтын мөрийг сонгоод, **Ctrl+V** (Windows) эсвэл **⌘ Command+V** (Mac) товчны хослолыг дарж, зургийн URL-г байрлуулан, Search by image товчийг дарна.
  - *Upload an image - Choose File* товчийг дарж, гарах харилцах цонхноос хэрэглэхийг хүссэн зургаа сонгоод, *Open* товчийг дарна.






- Хайлтын үр дүнг харах. Хэрвээ интернэтэд таны оруулсан зураг хаа нэгтээ байгаа бол ялгаатай хэмжээ болон хувилбараар энэхүү зургийг илрүүлнэ. Хэрвээ интернэтэд уг зураг байхгүй бол таны байршуулсан зурагтай ижил төстэй харагдах зургийг Google хайлтын систем илрүүлнэ.




### Гар утаснаас Google Chrome вэб хөтөч ашиглан хайлт хийх

- Google Chrome вэб хөтчийг нээх. Улаан, шар, ногоон өнгө бүхий Chrome аппликэйшны дүрс дээр товшино.




- Хайлтын мөр дээр дарах. Энэ нь дэлгэцийн дээр байрлана. Хэрвээ та хайлтын мөрийг олохгүй бол дэлгэцийн зүүн дээд буланд байрлах + дээр эхлээд дар.




- Хайх үгээ оруулах. Хайхыг хүсэж буй зурагтай холбоотой үг эсвэл хэлцийг бичиж өгөх ба дараа нь Go (iPhone) эсвэл Enter товч болон ✓ (Android) дээр дарна.






- IMAGES** таб дээр дарах. Энэ нь дэлгэцийн дээд хэсэгт буюу ердөө хайлтын мөрийн доор байрлана. Үүнийг хийснээр таны хайлтын хүсэлтэнд зориулж бүх зурган үр дүнгүүдийг дүрсэлнэ.



5. Хэрэглэх зургаа сонгох. Хайлтын үр дүнгээс хэрэглэхийг хүссэн зургаа сонгох үед зураг нээгдэнэ.



6. Зургийн доор байрлах  дарах. Үүнийг хийснээр доошоо задарсан цэс гарч ирнэ.
- Дэлгэцийн баруун дээд буланд байрлах  товч дээр дарахгүй.




7. **Search by image** товч дээр дарах. Энэ нь доошоо задарсан цэсэнд агуулагдана.


8. Үр дүнгээ хянах. Та энэ хуудаснаас ижил төстэй зургуудын жагсаалтыг харах боломжтой.

### Компьютераас Google Chrome вэб хөтөч ашиглан хайлт хийх


1. **Google Chrome** вэб хөтчийг нээх. Энэ нь улаан, шар, хөх, ногоон өнгийн бөмбөрцөг хэлбэртэй дүрс байна.



2. Хаягийн мөр дээр дарах. Энэ нь Chrome вэб хөтчийн дээр байрлана. Үүнийг хийснээр хаягийн мөрийн агуулга тодорно.




3. Хайх үгээ оруулах. Хайхыг хүсэж буй зурагтай холбоотой үг эсвэл хэлцийг бичиж өгөх ба дараа нь **↵ Enter** дарна.



4. **Images** таб дээр дарах. Энэ нь вэб хөтчийн дээд хэсэгт, хайлтын мөрний яг доор байрлана. Үүнийг хийснээр таны хайлтын бүх зурган үр дүнгүүд дүрслэгдэнэ.

- Хэрэв **Images** таб харагдахгүй бол табуудын байрлаж буй мөрний баруун талд байрлах *More* таб дээр дарах үед гарах доош задарсан цэснээс *Images* сонгоно.



5. Хэрэглэх зургаа сонгох. Хайлтын үр дүнгээс хэрэглэхийг хүссэн зургаа сонгох үед зураг нээгдэнэ.

## GOOGLE DOCS, SHEETS, SLIDES




Google Docs, Google Sheets, Google Slides нь Google компаниас хөгжүүлэн гаргасан, вэбэд суурилсан оффисын хэрэглээний багц програм юм. Эдгээр бүтээгдэхүүн нь хэрэглэгчдэд зориулсан үнэгүй, онлайн програмууд юм. Google Docs, Sheets, Slides нь вэб аппликэйшн болон андройд, iOS үйлдлийн системтэй төхөөрөмжүүдэд зориулсан гар утасны аппликэйшн байдлаар тус тус хөгжүүлэгдсэн.

Тиймээс та эдгээр онлайн оффисын програмуудыг вэб хөтчөөс, эсвэл гар утас, таблет зэрэг төхөөрөмжүүдээс тус тус ашиглаж болно. Эдгээрийг ашиглан та текст, хүснэгт, танилцуулга гэх мэт баримтуудыг онлайн орчинд үүсгэснээр тухайн файлууд руу хэзээ ч, хаанаас ч хандах боломжтой болно. Өөрөөр хэлбэл таны ашиглаж буй компьютер дээр оффисын хэрэглээний ямар нэг програм суулгах шаардлагагүй, зөвхөн интернэтэд холбогдсон байхад та баримтыг үүсгэх, хандах, тэр бүү хэл тэдгээр баримтыг бусадтай хуваалцах, хамтран ашиглах боломжтой юм. Google Docs, Sheets, Slides аппликэйшнүүд нь тус бүр Microsoft Office-ийн Word, Excel, Power Point програмуудтай ижил үйлчилгээг үзүүлнэ.

### **Google Docs, Google Sheets, Google Slides ашиглахын давуу талууд**

- Үүсгэсэн баримтууд нь Google-ийн сервэр дээр хадгалагдах тул таны компьютерийн хатуу диск эвдэрсэн ч таны баримтууд алдагдахгүй.
- Бичиг баримтын нууцлал Google-ийн хамгаалалтаар хамгаалагдах тул мэдээлэл алдагдах эрсдэлгүй.
- Та интернэтэд холбогдсон л бол өөрийн үүсгэсэн баримтуудад хаанаас ч, хэзээ ч хандах боломжтой.
- Баримтыг бусадтай хуваалцах боломжтой ба ингэснээр олон хэрэглэгч тухайн баримтыг нэг зэрэг нээж, засах боломжтой.
- Бусад үүлэн тооцооллын үйлчилгээнүүд нь төлбөр авдаг бол Google-н эдгээр үйлчилгээ нь үнэгүй.

### **Google Docs, Google Sheets, Google Slides програмуудын талаар товч танилцуулъя.**



## Google Docs

Google Docs програм нь бидний ашиглаж сурсан MS Office Word програмын онлайн хувилбар юм. MS Office Word програм дээр хийгддэг бүх үйлдэл, функцуудыг Docs дээр ашиглах боломжтой. Хэрхэн баримт үүсгэн, ашиглах талаар авч үзье.

- Вэб хөтчийг нээж, хаягийн мөрөнд <https://gmail.com> бичнэ.




- Өөрийн Gmail эрхээр нэвтэрч орно.


Email or phone


Ganbat@gmail.com|


- Гарч ирэх цонхны баруун дээд буланд байрлах *Google apps* товч дээр дарна.






- Програмуудын жагсаалт гарч ирэх ба үүнээс *Docs* програмыг сонгоно. Хэрэв *Docs* гэж харагдахгүй бол програмуудын жагсаалтын дор байрлах *More* дээр дарах үед бусад програмууд гарч ирнэ. Энэ хэсгээс сонгож өгнө.
- *Google Docs* програм луу үсрэх ба **Blank** сонголт нь шинэ баримт үүсгэх бол түүний араас байрлах бусад сонголт нь баримтын бэлэн загварууд юм. Та эдгээр загваруудаас авч ашиглаж болно.



- *Blank* сонголтыг сонгож шинэ баримт үүсгэсэн тохиолдолд автоматаар таны Google Drive-т хадгалагдана.
- Баримтад нэр өгөхдөө зүүн дээд буланд байрлах хэсэгт бичиж өгнө.  Хавтасны зурган дээр дарснаар файлын хадгалагдах замыг зааж өгч болно.



- Мөн  дээр дарснаар шинэ хавтас үүсгэн, тухайн хавтсанд хадгалж болно.



- Баримтын нэр солихдоо **File->Rename** сонголтыг сонгоно.

Google Docs нь тун хялбар програм юм. Та Microsoft Office Word програм дээр ажилладагтай ижил командуудыг ашиглана. Жишээ нь,

- Copy – Текст хуулах
- Paste – Хуулсан текстийг буулгах
- **Bold** – Текстийг тодруулах
- Underline – Текстийн доогуур нь зурах гэх мэт.

### Баримтыг вэбэд нийтлэх

Та баримтаа бусадтай хуваалцах зорилгоор инернэт болон олон нийтийн сүлжээнд нийтлэх боломжтой. Үүнийг хэрхэн хийх талаар авч үзье.

- **File->Publish to the Web** командыг сонгоно.
- Хаана нийтлэхийг зааж өгөх

Link Embed

Publish

- **Publish** товч дээр дарах үед уг баримт руу хандах боломжтой линк үүсэх ба уг линкийг та вэбэд байршуулснаар бусад хүмүүс энэхүү баримтын агуулгыг харах боломжтой болно. Доор нь байрлах **Stop publishing** товч дээр дарснаар нийтлэлийг цуцлах боломжтой. Баримт дээр хийгдсэн өөрчлөлт нь автоматаар нийтлэл дээр хэрэгжинэ.

[https://docs.google.com/document/d/e/2PACX-1vQhkM1AqKGB5DI9yK\\_x4KLHJ5nm](https://docs.google.com/document/d/e/2PACX-1vQhkM1AqKGB5DI9yK_x4KLHJ5nm)

Stop publishing


- Дараах сонголтуудаас сонгож, холбоосыг мэйлээр илгээж эсвэл Facebook зэрэг олон нийтийн сүлжээнд нийтэлж болно.



### Баримтыг бусадтай хамтран ашиглах (нээх, засах)

- Хамтран ашиглах файлыг нээх эсвэл үүсгэнэ.
- **File-> Email Collaborators** командыг сонгоно.

- Хамтран ажиллах хүнийхээ Gmail хаягийг People хэсэгт оруулна. Add a note хэсэгт мессэж бичиж болно.

-  товч дээр дарснаар хамтран ажиллах хүн уг баримтыг ямар эрхтэйгээр ашиглахыг зааж өгнө.
  - *Can edit* – Баримтыг засах эрх
  - *Can comment*- Баримтад тайлбар бичих эрх
  - *Can view* – Баримтыг зөвхөн харах эрх

## Google Sheets

Google Sheets нь Microsoft Office Excel шиг мэдээллийг хадгалах, зохион байгуулах боломжийг олгодог вэбэд суурилсан програм юм. Google Sheets нь MS Excel-ийн бүх дэвшилтэт функцүүдийг санал болгодоггүй боловч энгийн, цогц хүснэгтүүдийг үүсгэх, засварлахад хялбар байдаг. Хэдийгээр хүснэгтүүдийг зарим хүмүүс нарийн төвөгтэй тоо болон өгөгдлийг боловсруулахад хэрэглэдэг гэж боддог ч үнэндээ янз бүрийн өдөр тутмын ажилд ашиглахад тохиромжтой. Дараах алхмуудын дагуу Google Sheets үүсгэн хэрэглэнэ.

- Вэб хөтчийг нээж, хаягийн мөрөнд <https://gmail.com> бичнэ.



- Өөрийн Gmail эрхээр нэвтэрч орно.

[Email or phone](#)

Ganbat@gmail.com|

- Гарч ирэх цонхны баруун дээд буланд байрлах *Google apps* товч дээр дарна.



- Програмуудын жагсаалт гарч ирэх ба жагсаалтын дор байрлах *Even more from Google* дээр дарах үед бусад програмууд гарч ирнэ. Энэ хэсгээс Google Sheets програмыг хайж, түүний доор орших *Get started* дээр дарахад гарах сонголтуудаас *Use on the web* сонго.



- Google Sheets програм луу үсрэх ба **Blank** сонголт нь шинэ баримт үүсгэх бол түүний араас байрлах бусад сонголт нь баримтын бэлэн загварууд юм. Та эдгээр загваруудаас авч ашиглаж болно.
- Google Sheets програм дээр ажиллах нь MS Excel програмтай адил тул танд ашиглахад хялбар байх болно. Мөн өөрийн үүсгэсэн хүснэгтэн




баримтыг вэбэд, олон нийтийн сүлжээнд нийтлэх болон бусадтай хамтран ашиглах тохиргоо нь Google Docs дээр тайлбарласантай ижил байна.

## Google Slides

Google Slides нь онлайн танилцуулгын баримтыг үүсгэх боломжийг олгоно. Танилцуулгын баримт нь хөдөлгөөнт дүрс, зураг, видео зэргийг агуулж болно. Энэ нь бидний ашиглаж сурсан MS Office PowerPoint програмтай төстэй юм. Онлайн танилцуулгын баримыг үүсгэх, хадгалах, бусадтай хамтран ашиглах зэрэг үйлдэл нь өмнө тайлбарлагдсан Docs, Sheets програмуудтай ижил тул энд дахин тайлбарласангүй.

## GOOGLE FORUMS

Бид Google Forum ашиглан судалгааны асуулт, шалгалтын асуулт боловсруулах гэх мэтээр ажил болон сургалтанд ашиглах боломжтой. Судалгаа болон шалгалтын асуулт боловсруулж, хэрэглэгчдээр онлайнаар бөглүүлсний дараа үр дүнг хүснэгтэн файл (excel) хэлбэрээр авах боломжтой. Хүснэгтэн файлыг үүсгэсний дараа дахин өөр хэрэглэгч формыг бөглөх үед таны файл автоматаар шинэчлэгдэн хадгалагдана. Шалгалтын асуулт боловсруулах үед зөв хариулт болон асуулт бүрийн оноог оруулж өгснөөр уг формыг оюутан бөглөх үед нийт авсан оноо, буруу хариулсан тохиолдолд зөв хариуг харуулна. Үүсгэсэн формын холбоосыг блог, имэйл, фэйсбүүк зэрэг хаана ч байрлуулж болно. Хэрхэн форм үүсгэх талаар авч үзье.

- Gmail эрхээрээ нэвтэрч орно.
- Цонхны баруун дээд буланд байрлах  **Google apps** товч дээр дарна.
- Гарах жагсаатаас **Drive** сонго. 
- Зүүн дээд буланд байрлах **New** товч дээр дарна. **New->More->Google**
-  Google Forms
- Шинэ формын цонх гарч ирнэ.
- **Untitled form** дээр курсор байрлуулан, формын нэрийг өгнө.

## МОНГОЛ ХЭЛТЭЙ БАЙРШИЛ ТОГТООХ СИСТЕМ (GPS)

Анх Монгол улсад бидний сайн мэдэх “Оллоо аялалын хөтөч” OLLOO систем нь тусгай *ЖиПиЭс* төхөөрөмж ашиглан, Монгол орны газар нутгаар газрын зураггүй аялах боломжийг олгодог байсан бол техник технологийн хөгжлийн явцад ухаалаг гар утсыг ашиглан интернэт сүлжээнд хамааралгүй шууд байршил тодорхойлж, зам заах боломжтой болсон. *ЖиПиЭс-ийг анх цэргийн зориулалтаар 1973 оноос эхлэн судалж хэрэгжүүлсэн ба 90-ээд оноос бага багаар иргэний хэрэгцээнд ашиглуулж эхэлсэн.* Одоогоор олон нийтийн



хэрэгцээнд АНУ, ОХУ, Япон, Солонгос гэх мэт дэлхийн өндөр хөгжилтэй орнууд амжилттай хэрэгжүүлж байгаа. Дэлхийг тойроод хиймэл дагуулууд маш нарийн тойрог замаар өдөрт 2 удаа тойрдог бөгөөд дэлхий рүү дохионы мэдээллийг дамжуулж ЖиПиЭс хүлээн авагч нь уг мэдээллийг хүлээн авч, гурвалсан систем ашиглан байршлыг нарийн тогтоож өгдөг. Цаг агаарын ямарч нөхцөлд дэлхийн хаана ч 24 цагийн байнгын ажиллагаатай байдаг. 2010-оноос хойш ухаалаг гар утас үйлдвэрлэгч компаниуд «Location Service» буюу байршил тогтоох системтэй хийдэг болсноор энгийн хэрэглэгч бидэнд илүү ойр болсон.

Харин одоо монгол улсын 21 аймаг сумдын авто замын сүлжээг холбосон шинэ газрын зурагтай **GEONET GPS NAVIGATOR** -ын монгол хэлтэй ЖиПиЭс-ийн хувилбарыг Android болон IOS үйлдлийн систем ашигладаг төхөөрөмжүүдэд ашиглах боломжтой боллоо. Тус аппликейшнийг татаж авч туршилтын 7 хоног үнэгүй ашиглах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа төлбөр төлөөд цаашид ашиглах боломжтой.

### Системийн давуу тал


- Монгол цэс, дуу хоолойтой.
- Интернет сүлжээнээс хамааралгүй.
- Зам тооцоолж, хурд хэмжинэ.
- Хамгийн сүүлийн үеийн 3D газрын зурагтай.
- Явсан замын бичлэг хийж, тэмдэглэл хийнэ.
- Хэзээ ч, хаана ч төөрөхгүй, байнгын ажиллагаатай.
- Координат буюу өргөрөг, уртрагаар хайх
- Хот доторх түгжрэлийн талаар мэдээлэх системтэй гэх мэт маш олон үйлдэл болон давуу талуудтай.

### Системийн шаардлага

- IOS болон Android үйлдлийн систем ашигладаг хөдөлгөөнт төхөөрөмжүүд.
- IOS 5.1.1 хувилбараас дээш
- Android 4.0.1 хувилбараас дээш

### Аппликэйшн суулгах заавар

- Вэб хөтчийг нээж <http://www.iphone.mn/popular> хаягийг бичиж өгнө.
- “Ухаалаг гар утсанд Монгол хэлтэй GPS суулгах заавар” хэсгийг сонгоно.



- Доош гүйлгэн “Энд дар” хэсгийг товвшсоноор татах холбоосууд гарч ирэх ба “Android утсанд татах” хэсгийг сонгоно.

**ТАТАЖ АВАХ ЛИНК**

**iPhone болон АНДРОЙД утсанд татах бол ЭНД ДАР !!!**



- Татаж дууссаны дараа дараах байдалтай харагдах ба **GeoNet** аппликейшныг сонгож орно.



- Ямар хэл дээр ашиглахаа сонгоно.

Lietuvių

Монгол


- Системийн дуу хоолой болон зарим тохиргоог уншиж танилцан өөрт тохируулан сонгоно.

Дуу хоолойны багц сонгох


English female

Русский женский


- “Газрын зургийг интернэтээс татах уу?” гэж асуух ба Тийм гэж сонгох ёстой.



- Өөрийн улсын оршдог бүс нутгийг сонгож, газрын зургийг татна.




- Таны төхөөрөмжийн хиймэл дагуултай (**GPS**) холбогдох тохиргоо **On** буюу идэвхтэй байх ёстой. Идэвхжүүлэхийн тулд **Settings->Google->Location** хэсэг рүү орж идэвхжүүлнэ.



- iOS үйлдлийн систем бүхий гар утсанд уг аппликэйшныг суулгах дараалал дээрхтэй ижил хийгдэнэ.


### Аппликэйшныг ашиглах заавар

GeoNet аппликэйшн нь олон үйлдэл, функцүүдтэй тул та ашиглах зааврыг <https://www.youtube.com/watch?v=LzIqMFH6vZ8&feature=youtu.be> холбоос руу орж үзэж болно. Уг аппликэйшныг нээх үед таны идэвхтэй байгаа байрлалыг дүрслэх ба очихыг хүссэн газраа оруулж өгнө. Ингэснээр маршрут нь таны байрлаж байгаа цэгээс эхэлж чиглүүлэх ба очих газар хүртэлх боломжит бүх замыг гаргаж өгнө. Эдгээр боломжтой зам бүрийн хэдэн км болох, дундаж хурд хэдтэй явбал ямар хугацаа зарцуулах зэрэг тооцооллыг харуулна. Та эдгээр замуудаас хамгийн богино замыг сонгож болох ч, эхний зам нь төв замаар явах маршрут юм. Очихыг хүссэн газраа аймаг, сумын нэрээр, байгалийн үзэсгэлэнт газрын нэрээр, гэр хорооллын гудамжны нэрээр гэх мэт оруулахад боломжит бүх замыг гаргана. Жишээ нь, Улаанбаатар хотоос Завхан аймгийн Отгон сумын нутаг дахь Очирваань хайрхан уруу явах маршрут гаргахад боломжит 2 замын тооцоог дараах байдалтай гаргасан байна.



Зам заагч нь замын эргэлтүүд хэр ойртож байгааг, ШТС ойрхон хаана байрлаж байгааг харуулна. Мөн явах замдаа Архангай аймгийн Цэцэрлэг сумаар дайрч явах шаардлагатай болсон гэвэл газрын зургаас Цэцэрлэг сумыг олж дараад Дайрах хэсгийг сонгож маршрутаа өөрчилнө. Гэр хорооллын гудамжны нэрээр хайлт хийхийн тулд Цэс => Хайлт => Хаана => Хаягаар

хэсэгт хайх хороолол, гудамжны нэрийг бичнэ. Хайж олсон байршлаа сонгож **Очье** хэсгийг товшиж замаа тодорхойлно.



## НӨАТ-ЫН БАРИМТЫГ БҮРТГҮҮЛЭХ

Нэмэгдсэн өртгийн албан татварын шинэчилсэн хууль 2016 оны 1 сарын 1-с эхлэн албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Шинэчилсэн хуулиар иргэд худалдан авсан бараа бүтээгдэхүүнийхээ НӨАТ-д төлсөн мөнгөний 20%-ийг эргүүлэн авахаар болсон билнээ. Дараах зурагт иргэн 11000 төгрөгний худалдан авалт хийсэн бол НӨАТ-д төлсөн 1000 төгрөгний 20% болон 200 төгрөгийг буцаан авахыг тайлбарласан байна.



НӨАТ-ын буцаан олголтыг авахын тулд иргэд бараа худалдан авсан баримтаа **ebarimt.mn** цахим хуудсанд бүртгүүлэх шаардлагатай. Хэрхэн баримтаа бүртгүүлэх талаар зөвлөмжийг хүргэе.

## НӨАТ-ын урамшууллын буцаан олголтоо хэрхэн авах вэ?



## Алхам 1: ebarimt.mn цахим хуудсанд бүртгүүлэх

- Вэб хөтөч дээр **ebarimt.mn** линкийг оруулна.
- Нууц үг сэргээх, шинээр бүртгүүлэх холбоос дээр дарна.

Нууц үг сэргээх, шинээр бүртгүүлэх →

- Гарч ирэх харилцах цонхны “Шинээр бүртгүүлэх” табыг сонгож, шаардлагатай мэдээллүүдийг оруулна. Үүнд: өөрийн идэвхтэй ашигладаг имэйл хаяг, регистрийн дугаар, зурган дээр гарсан кодыг тус тус оруулж, Бүртгүүлэх товчийг дарна.

Нууц үг сэргээх

Шинээр бүртгүүлэх

- Таны цахим хуудсанд нэвтрэх нэр, нууц үг бүртгүүлсэн имэйл хаягаар тань ирэх тул имэйлээ шалгаж, “энд дар” холбоос дээр дарснаар шууд **ebarimt.mn** цахим хуудсанд нэвтрэнэ. Гарч ирсэн харилцах цонхны мэдээллүүдийг зөв, анхааралтай бөглөж “Хадгалах” товчийг дарна. Хэрэв та бүгдийг бөглөсөн бол “Таны бүртгэлийн мэдээлэл бүрэн орж, баталгаажсан байна” гэсэн мессэж гарсч, үндсэн хуудсанд шилжинэ.
- Та имэйлээр ирсэн нууц үгээ солихын тулд вэб хуудасны баруун дээд буланд байрлах хэрэглэгчийн нэр бүхий товч дээр дарна. Гарч ирэх цэснээс “Хэрэглэгчийн мэдээлэл” сонго.
- Нууц үг солих товч дээр дарж, та имэйлээр ирсэн нууц үгийг өөртөө санахад амар байхаар өөрчлөх боломжтой.

Засах

Нууц үг солих

**Алхам 2:**

- Вэб хөтөч дээр **ebarimt.mn** линкийг оруулна.
- Нэвтрэх нэр, нууц үгээ оруулж, өөрийн эхрээр нэвтэрч орно.
- Баримт бүртгүүлэх хэсэгт сугалааны дугаар болон үнийн дүнг оруулж, “Бүртгүүлэх” товч дээр дарна.


**Алхам 3: Хувийн мэдээллээ баталгаажуулах**

Хэрэв та ebarimt.mn цахим хуудсанд өөрийн бүртгэлээ зөв хийсэн бол дараа оны эхний улиралд НӨАТ-ын буцаан олголт таны дансанд шууд орно. Өөрөөр хэлбэл та дараах мэдээллийг үнэн зөв оруулсан байх хэрэгтэй.


- Хэрэглэгчийн овог, нэр
- Регистрийн дугаар
- Имэйл хаяг
- Утасны дугаар
- Албан татварын буцаан олголтоо авах Монгол улсад бүртгэлтэй банк, дансны дугаар

**Google Forums**

Бид Google Forum ашиглан судалгааны асуулт, шалгалтын асуулт боловсруулах гэх мэт ажил болон сургалтанд ашиглах боломжтой. Судалгаа болон шалгалтын асуулт боловсруулж, хэрэглэгчдээр онлайнаар бөглүүлсний дараа үр дүнг хүснэгтэн файл (excel) хэлбэрээр авах боломжтой. Хүснэгтэн файлыг үүсгэсний дараа дахин өөр хэрэглэгч формыг бөглөх үед таны файл автоматаар шинэчлэгдэн хадгалагдана. Шалгалтын асуулт боловсруулах үед зөв хариулт болон асуулт бүрийн оноог оруулж өгснөөр уг формыг оюутан бөглөх үед нийт авсан оноо, буруу хариулсан тохиолдолд зөв хариуг харуулна. Үүсгэсэн форумын холбоосыг блог, имэйл, фэйсбүүк зэрэг хаана ч байрлуулж болно. Хэрхэн форум үүсгэх талаах авч үзье.

- Gmail эрхээрээ нэвтэрч орно.
- Цонхны баруун дээд буланд байрлах  **Google app** товч дээр дарна.

- Гарах жагсаатаас **Drive**сонго. 
- Зүүн дээд буланд байрлах **New**товч дээр дарна. **New->More->Google Forms**сонго.








 Google Forms


- Шинэ формын цонх гарч ирнэ.
- **Untitled form** дээр курсор байрлуулсан, формын нэрийг өгнө. Жишээ нь: Шалгалтын асуултууд гэж орүүлъя.

**Untitled form** Шалгалтын асуултууд

- Question хэсэгт асуултыг орүүлж өгнө. “Оюутны нэр” гэж бичиж өгье.  
Question ОЮУТНЫ НЭР
- Асуултын баруун талд орших товч дээр дарснаар хариултын хэлбэрийг сонгож өгнө. *Short answer* – богино текст хариулт, *Paragraph* – их текст хариулт, *Multiple Choice* – олон сонголттой хариулт, *Checkboxes* – хэрээст талбар, *Dropdown* – жагсаалт гэх мэт олон хэлбэр байдаг. Short answer сонгоё.

Short answer

- Баруун талд байрлах  товч дээр дарснаар асуулт нэмэх боломжтой.
- Асуулт оруулах хэсгийн баруун доод буланд байрлах **Required**  идэвхжүүлснээр тухайн асуултыг заавал хариулах шаардлагатай болно.
- Асуултыг устгахын хүсвэл тухайн асуулт руу орж, баруун доод буланд байрлах  товч дээр дарна.
- Асуулт нь зураг агуулж болно. Энэ тохиолдолд асуулт оруулах хэсэг болон хариултын төрөл сонгох товч хоёрын дунд орших  товч дээр дарснаар зураг оруулах боломжтой болно. Зургийг интернэтээс хайх, google drive дээрээс, таны зургийн цомгоос, компьютерийн хатуу дискнээс гэх мэтийн аль нэгийг сонгож оруулна. Зураг асуултын доор байрлуулагдах ба зургийг хулганаар сонгосноор зургийн аль нэг булан дээрээс хулганыг чирч, түүний хэмжээг өөрчлөх боломжтой.
- Асуултын зүүн доод буланд байрлах  **ANSWER KEY** (0 points) дээр дарснаар асуулт оруулах хэсгийн баруун дээд буланд 10  **points** оноог оруулж өгнө. Харин хариултын төрлөөс шалтгаалан зөв хариултыг оруулж өгөх аргууд нь өөр өөр байна. Жишээ нь олон сонголттой асуултын зөв хариултыг оруулахдаа тухайн хариултуудаас зөв хариуг хулганаар нэг дарж өгснөөр сонгож өгнө. Богино хариултын хэлбэр дээр зөв хариултыг бичиж өгөх хэсэг байна.
- Форумыг бэлэн болсон гэж үзвэд цонхны баруун дээд буланд байрлах  SEND товч дээр дарснаар үүсгэсэн шалгалтын

асуултыг хэн нэгний имэйл хаяг руу илгээх, Facebook болон twitter-т байрлуулах гэх мэт боломжууд байна.  Settings товч дээр дарснаар тухайн оюутан нэг л удаа шалгалт өгөх эрхийг тохируулах, шалгалтын асуултуудыг холих гэх мэт бусад тохируулгуудыг хийх боломжтой.

- Оюутнуудын хувьд бидний үүсгэсэн шалгалтын асуултууд жишээ нь дараах байдалтай харагдах ба оюутан асуултуудыг бөглөөд SUBMIT товч дарна.

## Шалгалтын асуултууд

\* Required

Оюутны нэр \*

Б.Батханд

Дэлхийн хамгийн өндөр уулын нэр аль нь вэ? \*

5 points

- Everest
- McKinley
- Kilimanjaro
- Elbrus

Уулын нэрийг бичнэ үү? \*

10 points



Отгонтэнгэр

SUBMIT

- SUBMIT товч дарснаар дараах мэдээлэл гарна.

## Шалгалтын асуултууд

Your response has been recorded.

[View your score](#)

[See previous responses](#)



- *View your score* дээр дарах үед таны авсан оноо болон ямар асуулт дээр алдсан зэрэг мэдээллүүд гарна.

## Шалгалтын асуултууд

Total points 10/15 ?

Оюутны нэр \*

Б.Батханд

✗ Дэлхийн хамгийн өндөр уулын нэр аль нь вэ? \*

0/5

- Everest
- McKinley
- Kilimanjaro
- Elbrus

Correct answer:

- Everest

✓ Уулын нэрийг бичнэ үү? \*

10/10



Отгонтэнгэр

- Шалгалтын үр дүнг харахын тулд асуулт оруулах хэсгийн дээр байрлах **QUESTIONS** **RESPONSES** табын **RESPONSES**-г сонго. Шалгалтын үр дүн дараах 3 янзаар харагдах боломжтой. Үүнд:

**Summary** - нийт шалгалт өгсөн бүх оюутны үр дүнг нэгтгэж гаргана.

**Question** - асуулт бүрээр үр дүнг гаргана.

**Individual** - оюутан бүрийн үр дүнг тус тусад нь харах боломжтой.


SUMMARY

QUESTION

INDIVIDUAL

**Summary** таб дээр дарахад гарах үр дүнг жишээ болгон харуулъя.

Average 6 / 15 points	Median 5 / 15 points	Range 0 - 15 points
--------------------------	-------------------------	------------------------



## Frequently missed questions ?

Дэлхийн хамгийн өндөр уулын нэр аль нь вэ?

Уулын нэрийг бичнэ үү?

Correct responses

2 / 5

2 / 5


## Оюутны нэр

5 responses

Б.Батханд
Х.Сарнай
Д.Болор
Ц.Дорж
Ч.Чинбат


## Дэлхийн хамгийн өндөр уулын нэр аль нь вэ?


2 / 5 correct responses



## Уулын нэрийг бичнэ үү?

5 responses



Үүнээс гадна  товч дээр дарснаар нийт оюутнуудын үр дүнг хүснэгтэн файл (Excel) болгон авах боломжтой. Хүснэгтэн файлын бүтцийг жишээ болгон харуулъя.

	A	B	C	D	E
1	Timestamp	Score	Оюутны нэр	Дэлхийн хамгийн өндөр	Уулын нэрийг бичнэ үү?
2	11/18/2017 0:14:04	10 / 15	Б.Батханд	Elbrus	Отогонтэнгэр
3	11/18/2017 0:14:30	15 / 15	Х.Сарнай	Everest	Отогонтэнгэр
4	11/18/2017 0:15:01	0 / 15	Д.Болор	McKinley	Богд Хан уул
5	11/18/2017 0:15:31	0 / 15	Ц.Дорж	Kilimanjaro	Чингэлтэй зүрх уул
6	11/18/2017 0:16:10	5 / 15	Ч.Чинбат	Everest	Их Уул
7					

## ХЭРЭГТЭЙ САЙТУУДЫН ХОЛБООСУУД

### Компьютер, интернэт, сургалт

1. Мэйжикнэт ХХК Вирусны талаар: <http://www.viruscenter.mn>
2. Миком ХХК Вирусны талаар: <http://antivirus.mng.net/>
3. Компьютер таймс сонин: <http://www.computertimes.mn>
4. Компьютер, програмчлалын номнууд: <http://www.mcl.edu.mn/itbooks/>
5. Мэйжикнэт ХХК Мэдлэгийн сан: <http://www.magicnet.mn>
6. Алсын зайн сургалтууд: <http://www.e-learning.mn>

### Интернэтийн үйлчилгээний компаниуд

1. Мэйжикнэт: <http://www.magicnet.mn>
2. Миком: <http://www.micom.mn>
3. Бодиком: <http://www.bodicom.mn>
4. М-Си-Эс Ком: <http://www.mcscom.mn>
5. Рэйл ком: <http://www.railcom.mn>
6. Мобинэт: <http://www.mobinet.mn>
7. Эрдэмнэт: <http://www.erdemnet.mn>
8. OPENMIX: <http://www.openmix.org>
9. Internet Service Co.,Ltd: <http://www.iservice.mn/>
10. MN Domain registry: <http://www.nic.mn/>
11. WWW Express: <http://www.express.ub.mn/>
12. WebMN таны вэб эндээс эхэлнэ: <http://www.web.mn>
13. Weblog free web site statistics: <http://www.weblog.mn/>

### Програм хангамж, интернэт програмчлалын компаниуд

1. Мэдээллийн Технологийн үндэсний парк: <http://www.itpark.mn>
2. Поверсофт системс ХХК: <http://www.powersoft.mn>
3. Softnet: <http://www.softnet.mn>
4. Пихэл: <http://www.pixel.mn>
5. StarSoft: <http://www.starsoft.mn/>
6. Interactive: <http://www.interactive.mn/>
7. BSB: <http://www.bsb.mn>
8. НэтСофт: <http://www.netsoft.mn/>
9. Датаком ХХК: <http://www.datacom.mn>
10. NextLevel: <http://www.design.mn/>
11. ECM: <http://www.ecm.mn/> - интернэт програмчлалын компани
12. Speaker Group: <http://www.speaker.mn/> -Software development New development
13. АрвисСофт: <http://www.arvisoft.mn/>
14. FSoft: <http://www.fsoft.mn>
15. MITSCo.,Ltd: <http://www.mits.mn/>

### Ажлын байрны зуучлал

1. Humanfortis ХХК: <http://www.careermongolia.mn/>
2. Инвесско ХХК: <http://www.ajil.mn/>
3. Ажил олгогчдыг дэмжигч монголын анхны вэб портал:  
<http://www.businessmn.com>
4. Монголын Хvvhдийн байгууллага: <http://www.naiz.net>
5. Монголын Залуучуудын холбоо: <http://www.mongolianyouth.com>
6. Залуу Лидер клуб: <http://www.nlclub.org/>